СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
**СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

# ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Баруун-Урт сум

# АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Шалгуур үзүүлэлт-1: Мэдээний ирц, хамралт - 3

Шалгуур үзүүлэлт-2: Мэдээний бодит байдал, чанар - 5

Шалгуур үзүүлэлт-3: Хүн ам, өрхийн мэдээллийн сан - 9

Шалгуур үзүүлэлт-4: Бизнес регистрийн мэдээллийн сан - 11

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГАА

Шалгуур үзүүлэлт-5: Мал, тэжээвэр амьтдын тооллого - 13

Шалгуур үзүүлэлт-6: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа - 16

Шалгуур үзүүлэлт-7: Ажиллах хүчний судалгаа - 18

Шалгуур үзүүлэлт-8: Бусад тооллого, судалгаа - 21

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРТАЛЧИЛГАА

Шалгуур үзүүлэлт-9: Мэдээлэл тархаалт, вэб баяжилт, сурталчилгаа - 24

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХИРГАА, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгуур үзүүлэлт-10: Дотоод үйл ажиллагаа - 30

Шалгуур үзүүлэлт-11: Статистикийн сургалтын үйл ажиллагаа - 33

Шалгуур үзүүлэлт-12: Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа - 37

ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгуур үзүүлэлт-13: Шилэн данс - 38

Шалгуур үзүүлэлт-14: Санхүүгийн тайлан - 39

БУСАД АРГА ХЭМЖЭЭ - 41

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2024 ОН

2024.12.06

Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/77 дугаар тушаалаар баталсан “Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх журам”-ын дагуу нэгтгэж, 2021 оны А/77 болон 2022 оны А/53 дугаар тушаалуудаар батлагдсан брендбүүкийн үсгийн “Roboto” фондыг ашиглан бэлтгэн танилцуулж байна.

## БҮЛЭГ I. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/11 Баруун-Урт сум

2024 онд ирүүлэх мэдээ, тайлангийн
график батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 60.1.21 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 18, 19, 20, Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.21.2 дахь заалт, Үндэсний Статистикийн Хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Албан ёсны болон захиргааны статистикийн 2024 оны мэдээ, тайлангийн график батлах тухай" А/183 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэст "Сумаас гаргах мэдээний нэр төрөл, график"-ийг нэгдүгээр, "Аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах мэдээний нэр төрөл, график"-ийг хоёрдугаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, агентлагуудаас ирүүлэх "Захиргааны болон албан ёсны статистик мэдээний нэр төрөл, график"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны А/183 дугаар тушаалыг үндэслэн 2024 онд аймгийн Статистикийн хэлтэст сум, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийлүүлэх статистикийн бүтээгдэхүүний талаар аймгийн Засаг даргын А/11 дүгээр захирамжийг 3-н хавсралттайгаар гаргуулан сумдад болон ААНБ-д хүргүүлэн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж ажиллах талаар заавар, чиглэл өгч ажилласан.

Энэхүү захирамжийн 1-р хавсралтаар сумдаас нийлүүлэх бүтээгдэхүүнийг нэр төрөл, график, 2-р хавсралтаар аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас нийлүүлэх статистикийн бүтээгдэхүүний нэр төрөл, график, 3-р хавсралтаар захиргааны статистикийн бүтээгдэхүүний нэр төрөл, графикийг тус тус батлан гаргасан.

Аймгийн Засаг даргын
2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн
А/11 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС 2024 ОНД ИРҮҮЛЭХ МЭДЭЭ ТАЙЛАНГИЙН НЭР ТӨРӨЛ, ГРАФИК

| № | Мэдээ тайлангийн нэр | Мэдээ тайлангийн | | Мэдээ тайланг ҮСХ-нд ирүүлэх хугацаа* | Давтамж | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Маягт № | Батлагдсан огноо, № | | | 7 хоног | сар | улирал | жил |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН | | | | | | | | | |
| 1 | Аж ахуйн нэгж, байгууллагын 20... оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ (хавсралт) | ААНБ-1 | 2015.12.30 № 01/161 | 02 сарын 25 | 1 | | | | 1 |
| 2 | Аж ахуйн нэгж, байгууллагын 20... оны үйл ажиллагааны хураангуй мэдээ (хавсралт) | ААНБ-2 | 2015.12.30 № 01/161 | 02 сарын 25 | 1 | | | | 1 |



Уг графикийг сумд болон аж ахуйн нэгж байгууллагад хэлтсийн даргын албан тоотын хамт хүргүүлэн статистик мэдээллийг цаг тухай бүр гаргах ажилтны лавлагааг буюу нэр, утас, гарын үсгээр баталгаажуулан авч, өөрсдийн ажилдаа гарын авлага болгон ашиглаж байна. Мөн Улаанбаатар хотод байрлалтай уул уурхайн чиглэлээр манай аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын цахим хаягаар 2024 онд мөрдөх мэдээ тайлангийн захирамж болон мэдээний маягтуудыг хүргүүлсэн.




Оны эхэн дээр үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-уудад мэдээ тайлангийн графикийг аймгийн Засаг даргын захирамжийн хамтаар тархаагаад өгөх нь тухайн ААНБ хугацаандаа мэдээ тайлан гаргах, шинээр орсон мэргэжилтэн, албан хаагчдад мэдээ тайланг хугацаанд нь цуглуулж, шуурхай байдлыг хангахад дөхөм болдог.

## Шалгуур үзүүлэлт-1 Мэдээний ирц, хамралт

ҮСХ-ын даргын 2023 оны А/183 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заагдсан мэдээ, тайланг график дагуу 2024 онд 13 сум, 67 баг болоод ҮСХ-ноос ирүүлсэн хүрээний дагуу ААНБ-ын 2023 оны үйл ажиллагааны мэдээг 307 ААНБ (дэлгэрэнгүй /212 ААН/, хураангүй /95 ААН/), улирлыг мэдээнд ҮСХ-ноос хүрээгээр ирүүлсэн 201 ААНБ-ыг албан ёсны статистикийн мэдээлэлд хамруулсан.

Албан ёсны статистик мэдээ болон захиргааны мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх үүднээс аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Татварын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллаж, бизнес регистрийн санг баяжуулан үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт баяжилтыг хийж аж үйлдвэрийн салбарт 5, зоогийн газар 4, зочид буудал 6, хөрөнгө оруулалт 3, тээвэр 1, барилгын мэдээнд 13 ААНБ-ыг шинээр тус тус нэмж мэдээнд хамруулсан. Цаашид аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа газруудын хамрах хүрээг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

2024 оны байдлаар албан ёсны статистик мэдээнд шинээр 32 ААНБ-ыг хамруулан, мэдээний хүрээг нэмэгдүүлсэн.

| Салбар | 2023 | 2024 |
|---|---|---|
| Аж үйлдвэр | 3 | 5 |
| Барилга | 14 | 13 |
| Тээвэр | - | 1 |
| Зочид буудал | 4 | 6 |
| Зоогийн газар | - | 4 |
| Хөрөнгө оруулалт | - | 3 |

Аж үйлдвэрийн мэдээнд 1 аж ахуйн нэгж байгууллагын 2023 оны мэдээг үйл ажиллагаа явуулсан сараар нь нөхөн авч, мэдээллийг программд оруулж, мэдээний хамралтыг нэмэгдүүлсэн.

Мөн Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний мэдээллийн санг бий болгох хүрээнд аж үйлдвэрийн салбарын мэдээнд хувиараа хөдөлмөр эрхэлж буй савлагаатай цай-1, евро хашаа-1, блок-4, хуванцар цонх, хаалга үйлдвэрлэгч-1 зэргээс албан ёсны статистикийн батлагдсан маягтын дагуу сар бүрийн мэдээг авч, мэдээний хүрээг нэмэгдүүлэн ажилласан.

2024 онд нийлүүлэх албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн графикийн дагуу 7 хоногийн давтамжтай 1 мэдээ, 14 хоногийн давтамжтай 1 мэдээ, сарын давтамжтай 13 мэдээ, судалгаа 2, улирлын давтамжтай 10 мэдээ, хагас жилийн давтамжтай 4 мэдээ, жилийн давтамжтай 11 мэдээг сар, улирал, жилээр сум, ААН-ээс авч боловсруулан нэгтгэж тайлант хугацаанд цахимаар бүрэн дамжуулж ажилласан.




Хэлтсийн мэргэжилтэн бүр хариуцсан салбарын мэдээллийг мэдээлэл боловсруулах программаар шивж, хүснэгт үүсгэн мэдээний хавтаст он, сар, өдрөөр байршуулж тухайн салбарын он оны динамикийг бүрдүүлэн ажиллаж хэвшсэн.

Ингэснээр тухайн салбарыг шинээр орсон албан хаагчдад шилжүүлэн өгөхөд суурь мэдээлэл болж өгнө.

Энэхүү байршуулсан мэдээ тус бүрийн хүснэгтийг тухайн сар, улирлын мэдээний бааз мөн эсэх болон өмнөх оны мөн үеэс хэрхэн өөрчлөгдсөн, бусад алдаа байгаа эсэхийг хэлтсийн дарга болон ахлах мэргэжилтэн нягтлан шалгаж дамжуулдаг уламжлалтай.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, эдийн засгийн түүвэр судалгаа болон бусад тооллого судалгааны мэдээллийг графикт хугацаанд нь цахим хэлбэрээр дамжуулан ажиллаж байна.

## Цаг үеийн шаардлагаар ҮСХ-ноос гаргуулсан нэмэлт мэдээ тайлан, судалгаа

Цаг үеийн шаардлагаар ҮСХ-нд албан ёсны статистикийн мэдээллийн графикт тусгагдаагүй 6 төрлийн 7287 нэмэлт мэдээллийг цуглуулж, боловсруулан тогтоосон хугацаанд нь өгөв.

Хүснэгт 1. 2024 онд цаг үеийн шаардлагаар шаардсан мэдээлэл

| № | Мэдээллийн (мэдээ тайлан, судалгаа, биелүүлсэн үүрэг гэх мэт) нэр/сэдэв | Мэдээлэл шаардсан ҮСХ-ны нэгж, хугацаа, давтамж, мэдээллийн | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Нэгж | Хугацаа | Давтамж | Тоо |
| 1 | Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа | ЭЗСГ-ҮСХ | 4-р сар | 1 | 4121 |
| 2 | Гурилын үнийн судалгаа /Тогтсон цэг болон томоохон цэг, сумдаас/ | ЭЗСГ-ҮСХ | 4, 9-р сар | 2 | 106 |
| 3 | Үйлдвэрлэгчийн үнийн суурь солих улирлын судалгаа | ЭЗСГ-ҮСХ | 4, 7, 10-р сар | 3 | 30 |
| 4 | Малын ашиг, шим, нэмүү өртгийн түүвэр судалгаа | ЭЗСГ-ҮСХ | 10-р сар | 1 | 202 |
| 5 | Олон улсын өртгийн зэрэгцүүлэх үнийн судалгаа | ЭЗСГ-ҮСХ | 5-11-р сар | 9 | 2606 |
| 6 | Сагс өөрчлөх үнийн мэдээ | ЭЗСГ-ҮСХ | 10, 11-р сар | 2 | 222 |

**Шалгуур үзүүлэлт-2** Мэдээний бодит байдал, чанар

Албан ёсны статистикийн 2024 оны жилийн эцсийн байдлаар 40 нэр төрлийн давхардсан тоогоор 4718 мэдээллийг ҮСХ-ноос баталсан, зөвшөөрсөн маягт, аргачлалын дагуу цуглуулж, тогтоосон хугацаанд нь бүрэн дамжуулсан.

Албан ёсны статистикийн мэдээний хамралт, бодит байдлыг сайжруулах зорилгоор ҮСХ-ны даргын 01 тоот албан даалгаврууд гарч, хэрэгжилтийг нь улирал тутам тайлагнан ажиллаж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний мэдээллийн санг бий болгох зорилгоор ҮСХ-ноос 3 удаагийн тодруулгаар 13 сумын 125 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн иргэний мэдээлэл ирснийг сумдад хүргүүлэн бүрэн тодруулж дууссан. Дээрх 125 иргэний мэдээллийг нягтлан шалгаж, үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн салбарын ангиллаар кодлон, ҮСХ-нд хугацаанд нь дамжуулан ажиллалаа.

ХАӨМС-гийн сайжруулах ажлын хүрээнд программаар уншигдсан байршил тодорхойлоогүй 101 өрх, мэдээллийн санд ороогүй шинэ төрсөн 873 хүүхэд, нас барсан 348 хүн, ургийн овог 3, овог 51, нэр 10, регистрийн дугаар 2, хүйс 2, яс үндэс 6 нийт 74 иргэн, ХАӨМС-д алдаатай 710 өрх, 8569 хүн амын мэдээллийг бүрэн засвар хийсэн.

Сар, улирал, жилийн эцсийн мэдээнд хамрагдсан 20 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн зөрүүтэй байдлыг бизнес регистрийн санд шинэчилж оруулсан. Үүнд: давхардсан тоогоор үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн 8, давхар үйл ажиллагаа нэмсэн 2, үйл ажиллагааны эрхлэлтийн байдал болон дарга эрхлэгчийн мэдээллийг сольсон 6, хаягийн өөрчлөлт хийсэн 4, давхар бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг нэгтгэсэн 1 /регистрийн дугаар нь өөр боловч 1 аж ахуйн нэгж байгууллага/ байна.

Мөн бизнес регистрийн сангийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсээс хуулийн этгээдийн өөрчлөлт, хөдөлгөөний бүртгэлийн мэдээг улирал тутам гаргуулан авч, баяжилтыг нь хийн ажиллаж хэвшсэн.

Бизнес регистрийн санд сүүлийн 2 жил дараалан үйл ажиллагаа эхлээгүй, түр болон бүрэн зогссон, шалтгаантай 40 аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл ирснийг бүрэн тодруулж, дамжуулсан. Мөн хуулийн этгээдээс үүсгэн байгуулагдсан хэлбэр нь зөв эсэх, ямар хуулийн этгээдтэй нийлж эсвэл хуваагдаж байгуулагдсаныг нь тодруулахаар 13 аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл ирснийг тодруулан хугацаанд нь дамжуулаад байна.

| Үзүүлэлт | 2023 | 2024 |
|---|---|---|
| Мэдээллийн сангийн шинэчлэл | 103 | 277 |
| Өөрчлөлт орсон ААНБ | 14 | 29 |
| Шинээр бүртгэлд оруулсан ААНБ | 88 | 243 |
| Татан буугдсан ААНБ | 1 | 5 |
| Энэ онд санд шинээр нэмсэн ААНБ (хүрээгээр) | 89 | 315 |

ҮСХ-ны даргын А/168 дугаар тушаалаар албан ёсны статистикийн мэдээллийн алдааг илрүүлж, засвар баримтжуулалт хийх тухай журам батлагдаж ирснийг салбар хариуцсан ажилтнууд сум, ААНБ-аас цуглуулсан мэдээллээ шалгаж, илэрсэн алдааг залруулж мөрдөн ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудтай Аймгийн Засаг даргатай байгуулах 3 талт хариуцлагын гэрээнд мэдээ тайлангийн гаргалт, чанар, үнэн бодит байдал, тайлагналтыг тусган оруулж, биелэлтийг нь тооцож ажиллахаар болсон.

2024 оны жилийн эцсийн байдлаар албан ёсны статистик мэдээ тайланд 291 алдаа, улсын хэмжээний тооллого, судалгаагаар 453 алдаа нийт 744 алдааг илрүүлж, баримтжуулан, засвар өөрчлөлтийг хийлгүүлэн программд үнэн зөв мэдээллийг шивж оруулсан. Алдааны баримтжуулалтыг төрлөөр нь авч үзвэл санамсаргүй алдаа 370, хэмжилтийн алдаа 211, боловсруулалтын алдаа 109, хамралтын алдаа 54 тус тус гаргасан байна.

Мэдээ, тайланд илэрсэн алдаануудын баримтжуулалтыг тухай бүр нь хэлтсийн даргаар хянуулан sharepoint-д байршуулан ажиллаж байна. Баримтжуулалтаа улирлаар нэгтгэн Нэгдсэн статистикийн газрын хамтын ажиллагаа, арга зүйн хэлтэст хугацаанд нь тогтмол хүргүүлдэг. Алдааны баримтжуулалтыг хөтлөн ажилласнаар тухайн ААНБ-ынн мэдээнд гаргах алдаа багасах, хариуцлага нэмэгддэг давуу талтай.

Статистикийн мэдээллийн чанарыг хянах,
үнэлэх журмын 4 дугаар хавсралт

**СҮХБААТАР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН**
**МЭДЭЭ, ТАЙЛАНД ИЛЭРСЭН АЛДААНД ХИЙСЭН ЗАСВАР, ӨӨРЧЛӨЛТИЙН БАРИМТЖУУЛАЛТ**

| Аймгийн нэр | Аймгийн код | Нэгжийн нэр | Мэдээний үзүүлэл-тийн нэр | Алдааны утга | Засварласан /өөрчилсөн утга/ | Засвар, өөрчлөлт оруулсан шалтгаан | Засвар/ өөрчлөлт хийсэн огноо | Алдааны төрөл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сүхбаатар | 22 | Талын гал | 501, 507, 701, 706 | 0 | 2872776.6 | Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөцийн өмнөх оны үлдэгдэл тавиагүй | 2024.02.10 - 2024.03.15 | II |
| | | | 7-р бүлгийн 2, 5-р багана | 1550765.1 | 1550765.1 | Зарцуулсан зардлынхаа дүнг түүхий эд материалын оны эцэс дээр тавьсан. | | II |
| Сүхбаатар | 22 | Дөрвөлж | 401, 701 | 3630016.2 | 3798836.2 | Барилгын материалыг дахин борлуулахаар худалдан авсан барааны өртөгөөр задлаж тавьсныг түүхий эд материалын дүнд нэмж авсан. | | II |
| | | | 401, 701 | 401=701=36253.0 | 401=701=53566.5 | Түүхий эд материалын дүнд орох шатахууны зардлыг үйлчилгээний зардалд оруулж тооцсон. | | II |
| | | | 403, 601 | 403=601=33241.6 | 403=601=15928.1 | | | II |
| | | | 501 | 44769.04 | 24838.4 | Оны эхний материалаг эргэлтийн хөрөнгийн нөөцийн дүнг буруу тавьсан. | | IV |

Хэлтсийн ажилтнууд хариуцсан салбарын мэдээ тус бүрийг аж ахуйн нэгжээс цуглуулахдаа анхан шатны мэдээний үнэн бодит байдал, баталгаажуулалт, өмнөх он, өмнөх сар, улирлын мөн үетэй харьцуулан хянаж, шалгаж авдаг.




Улирал, жилийн эцсийн мэдээний үнэн бодит байдлыг хянах үүднээс аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж, ААНБ-ын улирал, жилийн санхүүгийн тайлан балансыг **www.mof.gov.mn** хаягаар нэвтрэх нууц кодыг ашиглан ААН бүрээр балансын дүнг шалган тулгалт хийн бодит байдалд хяналт тавьж ажилласан.

Мөн ХАА болон бусад салбарын мэдээний хувьд аймгийн нэгдсэн тоотой байх үүднээс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Боловсролын газар, Санхүү төрийн сан зэрэг холбогдох агентлагийн мэдээтэй дүн, нэрсийн жагсаалтыг тулган хамтран ажиллаж хэвшсэн.

Хэрэглээний үнийн мэдээ болон 7 хоногийн үнийн мэдээний бодит байдалд хэлтсийн дарга тогтсон цэгээс авч байгаа эсэх, барааны нэр төрөлд санамсаргүй байдлаар шалгалт хийж хянан ажилладаг. Үнийн мэдээг сумд, ААНБ-ыг хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс сар бүр судалсан мэргэжилтний гарын үсэг тамгыг даруулж баталгаажуулж авдаг.

Шинээр томилогдсон мэргэжилтэн, сумдын төрийн сангийн мэргэжилтэн болон хүн ам зүйн түшмэл, хөдөө аж ахуйн мэдээлэл хариуцсан түшмэл, аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэгч нар солигдож, өөрчлөгдсөн тухай бүр нь утсаар болон биечлэн мэдээ тайлан гаргахад анхаарах асуудлын талаар заавар зөвлөмжийг тогтмол өгч ажилласан.

Мөн 13 сумын Засаг даргын тамгын газрын мэргэжилтнүүдэд болон 67 багийн Засаг дарга нарт албан ёсны статистик мэдээллийг гаргах, цаашид анхаарах асуудал болон статистик мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журмаар сургалт хийлээ.

Цаг үеийн шаардлагаар нэмэгдсэн мэдээнүүдэд хамрагдсан ААНБ-ын дарга, нягтлан бодогч нарт батлагдсан маягт аргачлалыг арга зүйн зөвлөгөөг өгсөн.

### Бие даасан хяналт, шалгалт

Сумд болон ААНБ-уудад мэдээний үнэн бодит байдал, анхан шатны бүртгэл хөтлөлт, тооллого судалгааны мэдээллийн чанарыг тухайн өрхөд очиж газар дээр нь тулган шалгаж заавар, зөвлөмж өгсөн.



Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу нийт ажилтнууд өөрсдийн хариуцсан салбарын чиглэлээр 4-9 ААНБ-дад статистикийн мэдээг хэрхэн гаргаж байгаа байдал, жилийн эцсийн мэдээ балансын уялдаа зэргийг үзэж оны эхэнд мэдээ, тайлангийн талаар гарсан аймгийн Засаг даргын А/23 дугээр захирамж хэрэгжилтийн талаар сумд, ААНБ болон багийн Засаг дарга, ажил хариуцсан ажилтнуудын мэдээ, тайлан гаргалттай танилцан хянаж, шалган, ажилласан.

Үйлчилгээний салбарын үнэ болон хэрэглээний үнийн мэдээнд улирал тутам хяналтыг тавьж нийтдээ 13 аж ахуй нэгжээс ирсэн салбарын үнэ, хэрэглээний үнийн мэдээнд 4 сум, аймгийн төв 5 нэгж дээр нийтдээ 2 удаагийн хяналт шалгалтыг биечлэн болон утсаар хийн ажиллаж байна.





Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05-р сарын 28-наас 31-ний өдрүүдэд хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах нь Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдад хяналтын тооллого хийж ажилласан. Мөн Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нь ҮСХ-ноос ирсэн хяналтын багтай хамтарч хорогдол өндөртэй сумд буюу Баруун-Урт, Асгат, Эрдэнэцагаан сумдад хамтарсан хяналт шалгалтыг хийж заавар зөвлөмжийг газар дээр нь өгч мэдээлэл цуглуулалтад гар бие оролцсон.



Хяналтаар тухайн сумдын хагас жилийн малын түүвэр судалгааны зохион байгуулалт, программын хэвийн ажиллагаа, түүвэрлэлтэд сонгогдсон өрхийг тооллогод бүрэн хамруулсан эсэх, ажлын ерөнхий төлөвлөгөө, багуудын маршруттай танилцаж сумын тооллогын комисс болон комиссын гишүүдтэй уулзаж дүнгийн хурал хийн танилцуулсан.

Хэлтсийн дарга бөгөөд улсын байцаагч Т.Эрдэнэбат нь мэргэжилтнүүдийн цуглуулсан салбарын анхан шатны мэдээнүүдэд 4 удаа хяналт хийж, гарсан алдаа зөрчлийг дор бүр нь арилгуулж, цаашид анхаарч ажиллах санамжийг өгсөн.

ҮСХ-ноос share point-ийг нэвтрүүлж эхэлснээр мэдээ, тайлан, танилцуулга, тайлбар, тодруулгыг тухай бүрд нь хяналтыг хийн ажиллаж байна.

Хэлтсийн ажилтнууд хариуцсан салбарын хүрээнд аймгийн Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Ө.Нарантуяатай хамтран жилийн эцсийн санхүүгийн балансыг буруу гаргасан 35 аж ахуйн нэгжийн тайланд хяналтыг хийж алдааг засуулан хамтран ажилласан.

**Илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ**

Хэлтсийн ажилтнууд дотоод болон гадна хийсэн хяналт шалгалтаар сумд, аж ахуй нэгж байгууллагуудад илэрсэн 291 зөрчлийг тухай нэгжийн удирдлага болон мэдээ тайлан гаргадаг ажилтнуудад танилцуулан алдаагүй тайланг гаргуулан авч сар, улирал, жилийн мэдээнд хамруулан ажилласан бөгөөд анхан шатны бүртгэлийг сайжруулах талаар чиглэлийг өгч ажилласан.

Статистикийн хэлтэст ирүүлэх статистикийн бүтээгдэхүүний нэр төрөл, графикийг баталсан захирамж аваагүй буюу шинээр байгуулагдаж байгаа, аймгийн газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж байгаа гадна ААНБ-уудад салбар хариуцсан мэргэжилтнүүд тарааж мөрдлөг болгон ажиллаж байна.

## Шалгуур үзүүлэлт-3 Хүн ам, өрхийн мэдээллийн сан

13 сум, 67 багийн хүн ам, өрхийн мэдээллийн санг хэлтсийн мэргэжилтэн, зохион байгуулагч нар эрх бүхий кодоороо нэвтэрч, өөрсдийн хариуцсан сумын өөрчлөлт хөдөлгөөн, алдаануудыг тогтмол шалгаж, заавар зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Багийн Засаг дарга болон хүн ам зүйн мэргэжилтэн нарт шинэчилсэн хүснэгтэд орсон өөрчлөлтүүдээр заавар зөвлөмжийг өгч, мэдээлэл цуглуулах явцад асууж тодруулсан зүйлд нь тухай бүр нь хариулт өгч ажилласан.

Баяжилт, шилжих хөдөлгөөний бүртгэл

Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар программаар уншигдсан байршил тодорхойлоогүй-101, мэдээллийн санд ороогүй шинэ төрсөн 873 хүүхэд, нас барсан 348 хүн, ургийн овог 3, овог 51, нэр 10, регистрийн дугаар 2, хүйс 2, яс үндэс 6 нийт 74 иргэн, ХАӨМС-д алдаатай 710 өрх, 8569 хүн амын мэдээллийг бүрэн засвар хийсэн.



Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу хэлтсийн дарга Т.Эрдэнэбат, ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг, мэргэжилтэн О.Ундрах, С.Мөнхбаяр, Б.Сумъяа нар 13 сумын 67 багийн Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, дэвтрийн хөтлөлтийг өрхөд очиж 915, цахим болон программаар 7429 өрхийн мэдээллийг шалгаж засвар өөрчлөлтийг хийлгэж ажилласан.

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн үзүүлэлтэд өөрчлөлт хийгдээгүй байхад баг, сум, аймгийн түвшинд алдаа байхгүй, харин мэдээллийн санд шинээр нэмэгдсэн болон өөрчлөлт хөдөлгөөн хийгдсэнээс хойш гарсан алдааг баг тус бүр дээр цуглуулсан мэдээллээр санд өөрчлөлтийг оруулж, алдааг засан, баяжуулсан.

Чанар

ХАӨМС-н хариуцсан мэргэжилтэн эрх бүхий кодоороо өдөр тутам нэвтрэн орж, УБЕГ-ын тодруулга, байршил тодорхойгүй өрх, хүлээгдэж буй өрх, хүн ам, баталгаажуулах өрх, хүн ам, хандалтын тайлан, алдааны дэлгэрэнгүйг уншуулж, өрх, хүн амын алдааны протоколыг сумаар хөтлөн аймгийнхаа ХАӨМС болон статистик мэдээ хариуцсан ажилтнуудын хаалттай фэйсбүүк группэд байршуулж, чиглэлийг цаг алдалгүй өгч, алдааг тухай бүр нь засуулан ажиллаж байна.

ХАӨМС-гийн сайжруулах ажлын хүрээнд Баруун-Урт суманд 2024.01.29-ны өдөр танхимын сургалтыг ХАӨМС-ын хөтлөлт бүртгэл, засвар өөрчлөлт хийх талаар сургалт хийсэн, ХАӨМС-д хийсэн ажлын тайланг сар бүр сумдаас авч нэгтгэн ажиллаж байна.

2024 онд ХАӨМС-гийн үзүүлэлтийг төрийн байгууллагуудын мэдээллийн санд үндэслэн баяжуулах, программ хангамжийг шинэчлэх зорилгоор хаягийн тодруулга хийхэд анхаарах асуудлаар 13 сумын төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нар, хүн ам зүйн мэргэжилтнүүдэд цахим сургалтыг 06 дугаар сарын 13-ны өдөр хийлээ.

Хаягийн орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх системийн сургалтыг 13 сумын төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нар, хүн ам зүйн мэргэжилтнүүдэд цахим сургалтыг 10 дугаар сарын 15-ны өдөр хийлээ.

Хүснэгт 2. Хүн амын мэдээллийн сангийн бүрдэлд, 2024.11.30-ны байдлаар

| Үзүүлэлт | 2024 он |
|---|---|
| Ш4.1 Баяжилт, шилжилт хөдөлгөөний бүртгэл | |
| Баяжилт | |
| ХАӨМС-ийн төрөлт | 873 |
| УБЕГ-ын төрөлт | 873 |
| ХАӨМС-ийн нас баралт | 348 |
| УБЕГ-ын нас баралт | 348 |
| Шилжилт хөдөлгөөний бүртгэл | |
| Шилжилт 6 сараас дээш хугацаагаар баталгаажаагүй хүн ам | 314 |
| Шилжилт баталгаажаагүй нийт хүн ам | 580 |
| Шилжилт 6 сараас дээш хугацаагаар хүлээгдэж буй хүн ам | - |
| Шилжилт хүлээгдэж буй нийт хүн ам | 166 |
| Ш4.2 ХАӨМС-ийн чанар | |
| Үзүүлэлтийн алдаа | 9279 |
| Хүн амын үзүүлэлтийн алдаатай хүний тоо | 8569 |
| Өрхийн үзүүлэлтийн алдаатай өрхийн тоо | 710 |
| Өрхийн цэг тэмдэглэлт | 101 |

## Шалгуур үзүүлэлт-4 Бизнес регистрийн мэдээллийн сан




Бизнес регистрийн санд 2023 оны эцэст бүртгэлтэй ААНБ 1474, улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэл өөрчлөлтийн мэдээний жагсаалт зэргийг үндэслэн шинээр байгуулагдсан ААНБ-ын дарга, эрхлэгчтэй ярьж улсын бүртгэлийн гэрчилгээ тамга тэмдгийн хамтаар авчруулж БР-1 маягтаар мэдээг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 315 байгууллагаас авч мэдээллийн сангаа баяжуулаад байна.

Бизнес регистрийн сангийн мэдээ нь 14 хоног бүрээр мэдээллийн санд ордог болсон тул шинээр нэмэгдсэн аж ахуйн нэгж байгууллагын мэдээг тухай бүр авч баяжилтыг хийж ажилласан.

Статистикийн мэдээ, татвар, санхүү, нийгмийн даатгалын тайланд хамрагдаагүй, бизнес регистрийн санд сүүлийн 2 жил дараалан үйл ажиллагаа эхлээгүй, түр болон бүрэн зогссон, шалтгаантай 40 аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл ирснийг бүрэн тодруулж, дамжуулсан. Мөн хуулийн этгээдээс үүсгэн байгуулагдсан хэлбэр нь зөв эсэх, ямар хуулийн этгээдтэй нийлж эсвэл хуваагдаж байгуулагдсаныг нь тодруулахаар 13 аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл ирснийг тодруулан хугацаанд нь дамжуулаад байна.

Сар, улирал, жилийн эцсийн мэдээнд хамрагдсан 20 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн зөрүүтэй байдлыг бизнес регистрийн санд шинэчилж оруулсан. Үүнд: давхардсан тоогоор үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн 8, давхар үйл ажиллагаа нэмсэн 2, үйл ажиллагааны эрхлэлтийн

байдал болон дарга эрхлэгчийн мэдээллийг сольсон 6, хаягийн өөрчлөлт хийсэн 4, давхар бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг нэгтгэсэн 1 /регистрийн дугаар нь өөр болovч 1 аж ахуйн нэгж байгууллага/ байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтүүдийн мэдээллийг улирал тутам жагсаалтаар гаргуулан авч, бизнес регистрийн мэдээллийн санд тухай бүр нь баяжилтыг хийж байна.

**Хуулийн этгээдийн жагсаалт**

**2024-01-01** ны өдрөөс ~ **2024-04-02** ны өдрийг дуустал

| № | Бүртгэлийн төрөл | Өөрчлөлт | Регистр/ОНБ дугаар | Нэр | ХХД |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл | Дахин гэрчилгээ | 3673022 | Оргилширээт | 1211001063 |
| 2 | Шинэ бүртгэл | | 240301058 | Мөнхөд гэрэлтэх хундар | |
| 3 | Шинэ бүртгэл | | 240306097 | Сүхбаатар аймаг дахь Онгон сумын Энгүүн нөмөр нутгийн | |
| 4 | Шинэ бүртгэл | | 240122010 | Силвэр крест | |
| 5 | Татан буугдсан бүртгэл | | 2742535 | Овоот финанс ББСБ | 1215001001 |
| | | Эрхлэх үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт | | | |

Бизнес регистрийн санд хийгдэж байгаа баяжилтын үнэн бодит байдлыг хянах үүднээс ХАӨМС-тай тулгалт хийхээс гадна, улсын бүртгэлийн ерөнхий газрын сайтын **opendata.burtgel.gov.mn** хуудасны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээс байгууллагын регистрийн дугаараар болон нэрээр хайлт хийж, мэдээллийг шалган баталгаажуулан баяжилтыг хийдэг.




Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн өөрчлөлт, хөдөлгөөний бүртгэлээс 424 ААНБ-уудын мэдээллийг гаргуулан авч, 277 ААНБ-ын мэдээллийг шинэчилж БРС-нд өөрчлөлтийг тусгасан. Нийт 277 ААНБ-ын мэдээллийг тодруулснаас шинээр бүртгэгдсэн 243, татан буугдсан 5, мэдээллийг нь шинэчилсэн /дарга, эрхлэгчийн нэр, хаяг, оноосон нэр, утасны дугаар гэх мэт/ 29 ААНБ байсан.

Шалгуур үзүүлэлт-5

Тооллогын мэдээллийн чанар

## Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого

### Бэлтгэл ажил, зохион байгуулалт:



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр Дугаар А/666 Баруун-Урт сум

Жилийн эцсийн өрх, хүн ам болон мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1-ийн "в", "и", 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Засгийн газрын 2003 оны "Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай" 224 дүгээр тогтоол, Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2003 оны "Аймгийн мал тооллогын комиссын даргыг томилох тухай" 67 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жилийн эцсийн өрх, хүн ам болон мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг удирдан зохион байгуулж, хяналт тавих аймгийн комиссыг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Жилийн эцсийн тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 17-ны өдрийн хооронд зохион байгуулж, 12 дугаар сарын 23-ны өдрөөс 28-ны өдрүүдэд бүрэн, чанартай тушааж, нэгтгэхийг сумд, аймгийн тооллогын комиссын дарга, гишүүдэд үүрэг болгож, авах арга хэмжээ, зөвлөмж, чиглэлийг хоёрдугаар хавсралтаар батлагсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлагагүй хандсан сумын Засаг дарга, холбогдох албан тушаалтанд зохих хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээг авч ажиллахыг аймгийн тооллогын комиссын орлогч дарга (Б.Батбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.ИДЭРБАТ

**2024** оны жилийн эцсийн мал тооллогын сургалт, хяналтын зардлын тооцоог төсөвлөн, тооллого явуулах тухай болон түүнд зарцуулагдах хөрөнгөтэй холбоотой аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж, 11-р сарын 07-ны өдөр мал тооллогын зардлын тухай аймгийн Засаг даргын А/637 дугаар захирамж, 11-р сарын 28-ны өдөр тооллого явуулах тухай аймгийн Засаг даргын А/666 дугаар захирамжуудыг тус тус гаргасан.

Мал тооллогын зардалд аймгийн Засаг даргын А/637 дугаар захирамжаар зар сурталчилгаа, аймгийн комиссын гишүүдийн хяналт, сургалтын зардалд 20.0 сая төгрөгийг батлан гаргасан.

Сумдад мал тооллогын болон албан ёсны статистик мэдээний маягтууд, зааврыг 2024 оны 11 дүгээр сарын 25, аймагт ажиллах хариуцлагатай жижүүрийн утасны дугаар, ажиллах цагийн хуваарийн хамт 2024 оны 12 дугаар сарын 02-ны хугацаанд бүрэн хүргүүллээ.



Жилийн эцсийн мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын сургалтыг ҮСХ-ноос ХАОСТ-ын хэлтсийн ахлах статистикч Ж.Цогзолмаагаар ахлуулсан баг бүрэлдэхүүн ирж сургалтыг хамтран зохион байгуулж, аймгийн Засаг дарга үг хэлж нээлтийг хийж, мал аж ахуйн статистикч Б.Алтансувд "Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого-2024", хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах "Маягт нөхөх заавар, анхаарах асуудал" сэдвээр сумдад 2024.11.22-23-ны өдрүүдэд сургалт хийлээ. Сургалтад сумдын төрийн сангийн мэргэжилтэн, хүн ам зүйч, ХАА хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга, нийтдээ 109 албан хаагч нар оролцсон.

Тус сургалтаар жилийн эцсийн мал тооллого явуулах зорилго, ач холбогдол, хууль тогтоомж, албан ёсны статистикийн мэдээллийг гаргахад анхаарах асуудал, ХӨАМС-гийн шинэчилсэн программ хангамж, чанар, сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээний шинэчилсэн маягт, Мал тооллогын МТ-1 карт хөтлөх, программын хэрэглээ зэргийн мэдлэгийг олгож, мал тооллогын ажлыг зохион байгуулах бэлтгэл ажил,

мэдээлэл цуглуулахад анхаарах асуудал", тооллогын МТ-1 карт хөтлөх болон НЗҮ шинэчилсэн мэдээний дадлага ажлыг хийж сургалтаар олж авсан мэдлэгээ бататган ажиллалаа.



Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын аймгийн комиссын анхдугаар хуралдааныг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр аймгийн нутгийн удирдлагын ордны хурлын танхимд аймгийн орлогч дарга Б.Батбаатар нээлтийг хийж, 24 гишүүний бүрэлдэхүүнд хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нь энэ жилийн тооллогын онцлог, ач холбогдол, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, сумдад хяналтаар ажиллах, гишүүдийн сумд хариуцан чиглэл өгөх хуваариуд болон хяналтаар ажиллах удирдамжийг баталсан.



Тооллогын маягт, зааврыг судлах, маягтыг хуваарилах, үзүүлэлтүүдийг маягтад зоох, хэсгүүдийн зохион байгуулалт, хүн хүч, машин унаа, явах маршрут, хяналтын хэсэг, нийт гарах зардлуудыг нарийвчлан тооцож, сайтар бэлтгэн, 2024 оны 12 дугаар сарын 07-ны өглөө мал тооллогын ажил нэгэн зэрэг эхэлсэн бөгөөд 17-ны өдрүүдэд тооллого дуусах, сум бүр бог малыг нүд үзэн тоолж байгаа 30-50 өрхийн видео бичлэгийг чанарын шаардлага хангаан зохион байгуулж хийх, аймагт 12 дугаар сарын 20-нд тушаах, шивэлтийг аль болох эрт эхэлж 12-р сарын 25-ны өдөр урьдчилсан дүн гаргахад уялдааны шалгалтуудыг хийж дуусгах, бусад материалаа аймагт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр багтаан тушаах нэгдсэн график, төлөвлөгөөтэйгөөр ажлыг зохион байгуулж, заавар зөвлөмжийг өгч ажиллаж байна.



БАТЛАВ:
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

| № | [illegible] | Хариуцах эзэн | Хугацаа | [illegible] |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | О.Үндрах | 11-р сарын 28 | |
| 2 | [illegible] | [illegible] | 11-р сарын 28 | |
| 3 | [illegible] | О.Үндрах | 12-р сарын 02 | |
| 4 | [illegible] | О.Үндрах | 12-р сарын 02 | |
| 5 | [illegible] | О.Үндрах | 12-р сарын 03 | |
| 6 | [illegible] | О.Үндрах С.Мөнхбаяр | 12-р сарын 04 | |
| 7 | [illegible] | О.Үндрах С.Мөнхбаяр | 12-р сарын 04 | |
| 8 | [illegible] | [illegible] О.Үндрах С.Мөнхбаяр | 12-р сарын [illegible] | |
| 9 | [illegible] | [illegible] О.Үндрах С.Мөнхбаяр | 12-р сарын [illegible] | |
| 10 | [illegible] | [illegible] | 12-р сарын [illegible] | |
| 11 | [illegible] | [illegible] | 12-р сарын [illegible] | |
| 12 | [illegible] | О.Үндрах С.Мөнхбаяр | 12-р сарын [illegible] | |
| 13 | [illegible] | О.Үндрах | 12-р сарын [illegible] | |
| 14 | [illegible] | [illegible] О.Үндрах С.Мөнхбаяр [illegible] | 12-р сарын [illegible] | |
| 15 | [illegible] | [illegible] | 12-р сарын [illegible] | |
| 16 | [illegible] | О.Үндрах | 12-р сарын [illegible] | |

Мөн тооллогын хугацаанд хэлтсийн мэргэжилтэн нар хариуцлагатай жижүүрт гарч, хийх ажлын батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил үүргийг мөрдөн хэрэгжүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн тооллогын ажилд нийт 77 ажлын хэсэг гарч 303 хүн, 73 тээврийн хэрэгсэл ажиллаж байгаа бөгөөд аймгийн комиссын хяналт 13 суманд 9 ажлын хэсэг ажиллана. Мөн сумдын комиссын хяналт 1-2 ажлын хэсэг ажиллаж байна.

Цахим орчноор /вэб хуудас, фейсбүүк групп/ хийгдэх сурталчилгааны баннерыг ҮСХ-ноос ирүүлсэн материалыг аймгийн 3 вэб сайт, сумдын болон 15 гол фейсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд хүргэн ажилласан.

## Тооллогын хяналт

Мал тооллогын аймгийн комиссын гишүүдийн хурлаар 13 сумыг тус бүр хариуцах гишүүд батлагдаж 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс сумдтайгаа холбогдож үүрэг чиглэл өгч ажилласан ба энэ талаар комиссын гишүүдийн нэгдсэн чатад өдөр бүр тэмдэглэл оруулан ажиллаж байна.

Аймгийн тооллогын комиссын гишүүдэд урьд оны тооллогод гарч байсан асуудалд анхаарах, энэ удаагийн тооллогын онцлогийн талаар дахин танилцуулж, сумдад хийх хяналтын талаарх заавар зөвлөмж өгсний дагуу батлагдсан хяналтын чиглэлд 9 групп 12 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн 2-6 хоногийн хугацаанд удирдамжид заагдсан 19 ажлыг нэг бүрчлэн шалгаж гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь шийдвэрлэн заавар, зөвлөгөө өгч ажилласан нь тооллогын чанарт нөлөөлж, ач холбогдол өндөртэй зохион байгуулагдаж байна. Мөн сумдад аймгийн тооллогын хяналтаар ажиллаж байгаа комиссын гишүүд мэдээлэл цуглуулалтын явцтай газар дээр нь танилцаж, бог малыг нүд үзэн тоолж байгаа видео бичлэгийг гар бие оролцон хийж гарч буй хүндрэл бэрхшээл болон анхаарах асуудлын талаар сумдад чиглэл өгч ажилласан.



Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат Уулбаян, Түвшинширээ, ХАА хариуцсан мэргэжилтэн О.Ундрах нь Мөнххаан, Түмэнцогт сумдын тооллогын зохион байгуулалт, ажлын явц байдалтай танилцаж, тухайн сумын 10-аас доошгүй өрхөд биечлэн болон цаасаар хяналтыг, бог малыг тоолж буй видео бичлэгийг утсаар хийхээр төлөвлөсөн.

## Тооллогын мэдээллийн дамжуулалт

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын сумаас ирүүлэх 30-50 өрхийн бог малын видео бичлэгийг 12-р сарын 20, МТ-1 маягтын шивэлтийг 2024 оны 12-р сарын 25-ны хугацаанд сумд дуусган, шалгаж аймагт 12-р сарын 30-ны дотор хүлээн авч нэгтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

## Шалгуур үзүүлэлт-6

## Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

### Түүвэр судалгааны хамралт

Үндэсний статистикийн хорооноос нэгжийн түүвэр хийхийн өмнө сонгогдсон багийн Засаг даргатай холбогдож түүвэр хийх сарын 25-ны дотор хүн ам, өрхийн мэдээллийн сангийн хаягандаа амьдардаггүй өрхийн тэмдэглээг хийх чиглэлийг өгч ажилладаг. Түүвэрлэгдэн ирсэн түүврийн нэгжийн дагуу тухайн сумын багийн Засаг даргатай уулзан өрхүүдийг дахин тодруулж, маршрут гаргуулан, хөтөч авч судалгааг эхлүүлдэг.





Өрхөд суурилсан судалгааны жилийн хүрээ энэ онд дэлгэрэнгүй болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2024 оны 01 дүгээр сараас 3 мэдээлэл цуглуулагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Сар бүр аймгийн төвийн 2 нэгжийн 20 өрх, хөдөөгийн 3 нэгжийн 30 өрх хамрагдахаар хүрээ ирсний дагуу календарьчилсан төлөвлөгөө гарган, сумдад хүргүүлэн ажилласан.

2024 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар 13 сумын 48 багийн аймгийн төвийн 220, хөдөөгийн 400 нийт 620 өрх хамрагдсанаас 47 нөөц өрх хамруулсан байна.

### Мэдээллийн чанар

2024 оны 12 сарын байдлаар Үндэсний статистикийн хорооноос ирсэн 3409 тодруулгаас 200 тодруулгад дата дээр засвар хийж 3209 тодруулгад тайлбар бичиж хүргүүлсэн.

Мөн энэ оноос эхлэн мэдээлэл цуглуулагч нар ирсэн тодруулга бүрд нэгтгэл хийн харьцуулж алдааны давтамж дээр дүгнэлт хийн дахин алдаа гаргахгүй байх тал дээр ажиллаж байна. Алдаа гаргасан бүлэг тус бүрдээ мэдээлэл цуглуулагч нар сургалт хийж ажиллаж байна.




 

Өрхөд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулалтын хяналт, шалгалтыг сайжруулж, мэдээлэл цуглуулалт, дамжуулалтын алдааг бууруулах зорилгоор судлаач нар бусад судлаач нарын цуглуулсан мэдээллийг дахин шалгаж дамжуулдаг байхаар 2018 оноос зохион байгуулж сар болгон хэвшүүлэн ажиллаж, түүнийг хавсралтаар шалгалтын явцад гарсан алдаа дутагдлыг хөтөлж засварлах бүртгэлийг баталгаажуулан гаргасан.



БАТЛАВ
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА бөгөөд СУДАЛГААНЫ БАГИЙН АХЛАГЧ Т.ЭРДЭНЭБАТ

2022 ОНЫ .......-Р САРЫН ӨРХӨД СУУРИЛСАН СУДАЛГААНЫ НЭГЖ ШАЛГАХ ХУВААРЬ

| С/Д | Шалгалтын тэмдэглэл | | | | | | | | | | Тодруулга хийсэн байдал | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2202 | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | | |
| | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | | |
| 2203 | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | | |
| | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | | |
| 2204 | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | | |
| | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | | |
| 2205 | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | | |
| | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | | |
| 2206 | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | Нэгж: | | | |
| | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | Ө: | Д: | | |

ТАЙЛБАР: С/Д-Судлаачийн дугаар /С/Д багана дах хоосон зайд тухайн сард шалгалт хийсэн судлаачийн дугаар байна/
Нэгж-Шалгуулах нэгжийн дугаар /Ө-Шалгуулахаар өгсөн сар, өдөр Д-Шалгаж дууссан сар, өдөр/
2202-А.Дарьзав, 2203-С.Мөнхбаяр, 2204-Э.Алтангэрэл, 2205-У.Мөнхбат, 2206-Б.Нандинчимэг

ХУВААРЬ ХИЙСЭН: СУДЛААЧ ........................ /.............................. /



Хэлтсийн даргын баталсан өрхөд суурилсан судалгааны нэгж шалгах хуваарийн хавсралт

.......... ДУГААРТАЙ СУДЛААЧИЙН .......... -Р САРЫН ШАЛГАСАН НЭГЖИД ГАРСАН АЛДАА, ТОДРУУЛГА

| Нэгж | Шалгалтын тэмдэглэл | Тодруулгын хэсэг, тайлбар |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |

ТАЙЛБАР: Нэгж-Шалгуулах нэгжийн дугаар
2202-А.Дарьзав, 2203-С.Мөнхбаяр, 2204-Э.Алтангэрэл, 2205-У.Мөнхбат, 2206-Б.Нандинчимэг

Өрхөд суурилсан судалгааны мэдээллийн чанарыг сайжруулах хүрээнд Хэлтсийн дарга бөгөөд судалгааны багийн ахлагч болон сар бүр хянагчаар томилогдсон мэргэжилтнүүд мэдээлэл цуглуулагч нарын сар бүр мэдээлэл цуглуулалтад хяналт хийж мэдээллийн чанарт анхаардаг.

### Утсан буюу алсын хяналт

Түүвэр судалгааны хамралтад ахлагч бүртгэлээр хяналт тавихын тулд мэдээлэл цугуулагч нараас хамрагдсан өрхүүдийн нэр, холбоо барих утасны дугаар бүхий хяналтын лавлагааны хуудсыг сар бүр тогтмол гаргуулж, өрхтэй холбогдон мэдээлэл цуглуулах явц болон өдрийн тэмдэглэлийг хэрхэн хөтөлж байгааг тодруулан заавар зөвлөгөөг өгч ажилладаг.

Энэхүү чиглэлээр 2024 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар газар дээр нь очиж 105 өрх, утсаар 260 өрхтэй холбогдон хяналт хийсэн байна.



Судалгаанд хамрагдсан өрхийн мэдээллийг шалгах явцад тухайн өрхөөс лавлах зүйл гарвал утсаар нь холбогдож, чөлөөтэй харьцахын тулд энэхүү лавлагааг хийн ажиллаж байгаа нь бидэнд олон талын үр дүнг өгч байна.

### Мэдээллийг нэг бүрчлэн шалгах хяналт

Сар бүр мэдээлэл цуглуулагч нар мэдээллээ цуглуулан нэгтгэн кодолж судлаачийн сервер рүү дамжуулсны дараагаар ахлагч татаж аван өөрийн таблет дээр нэг бүрчлэн шалган дамжуулдаг.

**Мэдээлэл дамжуулалт**

Хөдөөгийн нэгжид явсан судлаач сар бүрийн 30-ны дотор, аймгийн төвийн судлаач дараа сарын 5-ны дотор /улиралтай сард 3-ны дотор/ ахлагчийн серверт мэдээлэл дамжуулдаг.

Ахлагч  сервер лүү татаж авсны дараагаар шалгаж дараа сарын 8-ны дотор /улиралтай сард 5-ны дотор/ ахлагчийн серверт хугацаанд дамжуулж ажилласан.

### Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны модуль судалгаа

**Ардчилсан засаглал судалгаа**

Ардчилсан засаглал судалгаа нь 2024 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар 4 улирлын 100 өрхийг судалгаанд хамруулсан.

Судалгааг сонгогдсон нэгжид явуулахдаа судлаачид ҮСХ-ноос өгсөн заавар аргачлал, зөвлөмжийг мөрдлөг болгон мэдээллийг цуглуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дамжуулах хугацаанд Үндэсний статистикийн хорооноос судлаач болон ахлагчийн серверт дамжуулдаг.

**Шалгуур үзүүлэлт-7**

### Ажиллах хүчний судалгаа

**Түүвэр судалгааны хамралт**

Судалгааны зохион байгуулалтыг ӨНЭЗС-ны адил ҮСХ-оос өгсөн заавар, аргачлал, зөвлөмжийг мөрдлөг болгон мэдээллийг цуглуулж ажилладаг.

Үндэсний статистикийн хорооноос өгсөн заавар чиглэлийн дагуу , түүвэрлэгдэн ирсэн түүврийн нэгжийг тухайн сумын багийн Засаг даргатай уулзан өрхүүдийг дахин тодруулж, маршрут гаргуулан, хөтөч авч судалгааг эхлүүлдэг.








2024 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар давхардсан тоогоор 13 сумын 29 багийн аймгийн төвийн 190, хөдөөгийн 400 , нийт 590 өрх хамрагдсанаас 17 нөөц өрх хамруулан ажилласан байна.

**Мэдээллийн чанар**

2024 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар Үндэсний статистикийн хорооноос ирсэн 1101 тодруулгаас 273 тодруулга дата дээр засвар хийж  828 тодруулгад тайлбар хүргүүлсэн.

Өрхөд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулалтын хяналт, шалгалтыг сайжруулж, мэдээлэл цуглуулалт, дамжуулалтын алдааг бууруулах зорилгоор судлаач нар бусад судлаач нарын цуглуулсан мэдээллийг дахин шалгаж дамжуулдаг байхаар хуваарийг баталж, түүний хавсралтаар шалгалтын явцад гарсан алдаа дутагдлыг хөтөлж засварлах бүртгэлийг баталгаажуулан гаргасан.

Хэлтсийн дарга бөгөөд судалгааны багийн ахлагч судлаач нарын мэдээлэл цуглуултад 3-н төрлийн хяналтыг хийж мэдээллийн чанарт анхаардаг. Үүнд:







✓ Утсан буюу алсын хяналт

Түүвэр судалгааны хамралтад ахлагч бүртгэлээр хяналт тавихын тулд судлаач нараас хамрагдсан өрхүүдийн нэр, холбоо барих утасны дугаар бүхий хяналтын лавлагааны дагуу өрхтэй холбогдон мэдээлэл цуглуулсан явцад хяналтыг хийж ажилладаг.

✓ Ахлах болон мэргэжилтнүүдийн хяналт



2024 онд Мэдээлэл цуглуулагч нарын мэдээлэлд хяналт хийх хуваарийн дагуу 2024 оны 12 сарын 08-ны байдлаар Ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг, Мэргэжилтэн О.Ундрах, Б.Сумъяа, С.Мөнхбаяр нар нь хариуцсан сар бүртээ өрхөд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад хяналт хийн, мэдээлэл цуглуулагч нарт заавар зөвлөгөө өгч нийт 365 өрхөд хяналт хийснээс утсаар 260, биечлэн очиж 105 өрхөд хяналт хийн ажилласан байна.





| | *Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа* | |
|---|---|---|
| | *Ш7.1 Түүвэр судалгааны хамралт* | |
| | *Хамрагдвал зохих өрхийн тоо* | *660* |
| | *Нөөц өрхийн тоо* | *47* |
| | *Хамрагдаагүй өрхийн тоо* | *2* |
| | *Ш7.2 Мэдээллийн чанар* | |
| | *Нийт үзүүлэлтийн тоо* | *3409* |
| | *Алдаатай үзүүлэлтийн тоо* | *200* |
| | *Ш7.3 Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт* | |
| | *Хугацаа хоцорсон хоногийн тоо* | *0* |

| | *Ажиллах хүчний судалгаа* | |
|---|---|---|
| | *Ш8.1 Түүвэр судалгааны хамралт* | |
| | *Хамрагдвал зохих өрхийн тоо* | *640* |
| | *Нөөц өрхийн тоо* | *17* |
| | *Хамрагдаагүй өрхийн тоо* | *0* |
| | *Ш8.2 Мэдээллийн чанар* | |
| | *Нийт үзүүлэлтийн тоо* | *1101* |
| | *Алдаатай үзүүлэлтийн* | *273* |
| | *Ш8.3 Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт* | *0* |
| | *Хугацаа хоцорсон хоногийн тоо* | *0* |

2024 оны 09 сарын 18-ны өдөр зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдрөөр мэдээлэл цуглуулагч нар нь Өрхөд суурилсан судалгааны зорилго зорилт, ач холбогдол, хамрах хүрээ, дүн шинжилгээ, үр дүнгийн талаар мэдээ, мэдээлэл бэлтгэн иргэдэд танилцуулж, бэлтгэсэн мэдээллээрээ гарын авлага хийж тархаан ажилласан болно.






## Судалгааны мэдээлэл цуглуулах явц

Энэ онд манай аймгийн хувьд өвөлжилт хүндэрч төмөр зудын байдалд шилжиж цас их орж зам хаагдах, машин эвдрэх, цасанд суух, мэдээлэл цуглуулахаар гараад замаас буцах, малчид малын хорогдол ихтэй сэтгэл санааны хямралд орсон зэрэг нь өрхөд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулах явцад мэдээлэл цуглуулагч нарын хувьд хүндрэл бэрхшээлүүд их тулгарч байсан ба түүгээр зогсохгүй зудын дараа их цас хайлж шар усны үер болон машин шаварт суух, эвдрэх гэх мэт асуудлууд гарсаар байсан хэдий ч мэдээлэл цуглуулагч нар нь мэдээллийн чанар, үнэн бодит байх тал дээр хичээнгүйлэн ажилласан болно.



## Шалгуур үзүүлэлт-8 Бусад тооллого, судалгаа

**Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа**



Монгол хэлний тухай хууль, Засгийн газраас баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” 2020-2024-ийн хэрэгжилтийг үнэлэх “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны хооронд орон нутгийн бүх төрийн албан хаагчийг судалгаанд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж явуулсан.

Дээрх судалгааны талаарх мэдээлэл, шторкыг хэлтсийн вэб сайт, фэйсбүүк хуудас, төрийн мэдээллийн нэгдсэн сан erp.e-mongolia.mn дээр байршуулан мэдээллийг олон нийтэд сурталчилсан. Мөн судалгааны явцын талаарх мэдээллийг erp.e-mongolia.mn өдөр тутам мэдээлж, идэвхжүүлэн ажиллалаа.

“Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны ач холбогдол, асуулга, нөхөх заавар, 2021 оны судалгааны аймгийн үр дүнгээр сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд танхим болон цахимаар зохион байгуулж явуулсан бөгөөд сургалтад агентлаг, албад, хэлтсийн дарга нар, 13 сумын төрийн сангийн мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийг тодорхойлох судалгааны хяналтын тооллогоор 10 төрийн албан хаагч түүвэрлэгдэн ирснээс судалгааг бүрэн авч дамжуулсан.

### ХАГАС ЖИЛИЙН МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА

**Бэлтгэл ажил, зохион байгуулалт**

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хагас жилийн малын түүвэр судалгааг 2024 оны 05-р сарын 27-ноос 6-р сарын 04-ний хүртэлх хугацаанд мэдээлэл цуглуулалтын ажлыг амжилттай зохион байгуулж явуулсан.



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 16 өдөр Дугаар А/293 Баруун-Урт сум

2024 оны хагас жилийн малын түүвэр судалгааг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1-ийн "в", 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.21.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хагас жилийн малын түүвэр судалгааг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

Хагас жилийн малын түүвэр судалгааг орон нутагт зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг Засаг даргын орлогч дарга, сумдын тооллогын комиссыг сумын Засаг даргаар тус тус ахлуулан аймгийн Засаг даргын 2024 оны 05-р сарын 16-ны өдрийн А/293 дугаар захирамж гарч, тооллогын комисс, комиссын гишүүдийг, түүвэр судалгаанд баримтлан ажиллах үүрэг чиглэлийг баталсан.



2024 оны 05-р сарын 20-ны өдөр сумдын тооллогын комиссын дарга, гишүүд нийтдээ 13 сумын 134 албан хаагчдад хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нь тооллогын ерөнхий зохион байгуулалт болон мэдээлэл цуглуулалтын чанарт анхаарах, баримтлан ажиллах үүрэг чиглэл, хэлтсийн ХАА хариуцсан мэргэжилтэн О.Ундрах нь хагас жилийн малын түүвэр судалгааны маягтын үзүүлэлтүүдийн талаарх сургалтыг цахимаар хийсэн. Түүвэр судалгааг чанартай зохион байгуулж явуулахын тулд хэлтсийн даргаар хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тооллогын хугацаанд сумд хариуцан ажиллах мөн хариуцлагатай жижүүрийн хуваарь зэргийг батлуулж мөрдөн ажилласан.

## Мэдээлэл цуглуулалт

Энэ онд 2281 өрх, 13 ААНБ түүврээр сонгогдож, тооллогод 59 группын 130 гаруй хүн ажилласан.



Сумд хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааны бэлтгэл ажлын талаарх мэдээллийг 5-р сарын 26-нд, тооллогын явцын мэдээг 5-р сарын 27-ноос эхлэн 2 хоног тутам, шивэлтийн мэдээг 6-р сарын 2-ноос эхлэн өдөр бүр 2 удаа нэгтгэлийг хийж ажиллалаа.

## Тооллогын хяналт



Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05-р сарын 28-наас 31-ний өдрүүдэд хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах нь Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдад хяналтын тооллого хийж ажилласан. Мөн Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нь ҮСХ-ноос ирсэн хяналтын багтай хамтарч хорогдол өндөртэй сумд буюу Баруун-Урт, Асгат, Эрдэнэцагаан сумдад хамтарсан хяналт шалгалтыг хийж заавар зөвлөмжийг газар дээр нь өгч мэдээлэл цуглуулалтад гар бие оролцсон. Хяналтаар тухайн сумдын хагас жилийн малын түүвэр судалгааны зохион байгуулалт, программын хэвийн ажиллагаа, түүвэрлэлтэд сонгогдсон өрхийг тооллогонд бүрэн хамруулсан эсэх, ажлын ерөнхий төлөвлөгөө, багуудын маршруттай танилцаж сумын тооллогын комисс болон комиссын гишүүдтэй уулзаж дүнгийн хурал хийн танилцуулсан.



Сумдад ажиллахдаа анхан шатны мэдээ, тооллого судалгааны явц байдал, хөдөө аж ахуйн тооллогод хамрагдсан өрхийн мэдээллийг газар дээр нь очиж цуглуулж буй байдалтай танилцаж, мэдээний үнэн бодит байдал, анхан шатны бүртгэл хөтлөлт, тооллого судалгааны мэдээллийн чанарт анхаарч ажиллах тал дээр заавар зөвлөмжийг өгсөн.





Хариуцлагатай жижүүр өдөр бүр сумдаас явцын мэдээг нь авч нэгтгэн удаашралтай байгаа сумдтай холбогдож үүрэг чиглэлийг өдөр бүр өгч ажилласан тул тооллогын ажил хугацаандаа амжилттай зохион байгуулагдсан. Шивэлтийг дууссаны дараагаар сумдын цуглуулсан мэдээллийг сарын мэдээтэй уялдуулан шалгаж тодруулга засварыг тухай бүр нь хийж ажилласан. Хагас жилийн мал тооллогын мэдээллийг цуглуулж, үр дүнг нэгтгэн 2024 оны 06 дугаар сарын 15-ны хугацаанд ҮСХ-нд дамжуулсан.

**ХАГАС ЖИЛИЙН МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ШИВЭЛТИЙН ЯВЦ.** 2024.06.06-ны байдлаар

| Сум | НИЙТ ДҮН | | | Өрх | | | ААНБ | | | Шивэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Мэдээлэл оруулаагүй | Мэдээлэл оруулсан | Бүгд | Мэдээлэл оруулаагүй | Мэдээлэл оруулсан | Бүгд | Мэдээлэл оруулаагүй | Мэдээлэл оруулсан | |
| Баруун-Урт сум | 341 | 1 | 340 | 341 | 1 | 340 | 0 | 0 | 0 | 99.7 |
| Асгат сум | 104 | 0 | 104 | 102 | | 102 | 2 | | 2 | 100.0 |
| Баяндэлгэр сум | 247 | 0 | 247 | 246 | | 246 | 1 | | 1 | 100.0 |
| Дарьганга сум | 166 | 0 | 166 | 166 | | 166 | 0 | | 0 | 100.0 |
| Мөнххаан сум | 232 | 0 | 232 | 231 | | 231 | 1 | | 1 | 100.0 |
| Наран сум | 84 | 0 | 84 | 82 | | 82 | 2 | | 2 | 100.0 |
| Онгон сум | 148 | 0 | 148 | 147 | | 147 | 1 | | 1 | 100.0 |
| Сүхбаатар сум | 207 | 18 | 189 | 206 | 18 | 188 | 1 | 0 | 1 | 91.3 |
| Түвшинширээ сум | 170 | 0 | 170 | 170 | | 170 | 0 | | 0 | 100.0 |
| Түмэнцогт сум | 100 | 0 | 100 | 98 | | 98 | 2 | | 2 | 100.0 |
| Уулбаян сум | 139 | 0 | 139 | 139 | | 139 | 0 | | 0 | 100.0 |
| Халзан сум | 92 | 0 | 92 | 91 | | 91 | 1 | | 1 | 100.0 |
| Эрдэнэцагаан сум | 264 | 0 | 264 | 262 | | 262 | 2 | | 2 | 100.0 |
| **Нийт** | **2 294** | **19** | **2 275** | **2281** | **19** | **2262** | **13** | **0** | **13** | **99.2** |

Үйлдвэрлэгчийн үнийн суурь судалгаа

Үйлдвэрлэгчийн үнийн суурь солих судалгаа нь улсын хэмжээнд энэ онд зохион байгуулагдан явагдаж байгаа бөгөөд манай аймгийн хувьд 4 салбарын 9 /аж үйлдвэрийн 4, тээврийн 2, зоогийн газрын 2, зочид буудлын 2/ аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж байна.

Уг судалгаа нь түүвэрлэгдэн ирсэн 9 аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүний үнийг сарын 15-ны байдлаар цуглуулан авч, улирлаар PPIBase программд шивж, Үндэсний статистикийн хороонд дамжуулан ажиллаж байна.

Олон улсын өртгийн судалгаа

ОЛОН УЛСЫН ӨРТГИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТИЙН ХӨТӨЛБӨР 2024 хүрээнд өрхийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн судалгааг 2024 оны 5 дугаар сарын 15-наас хүнсний бараа, ундаа, усны бүлэг, архи, согтууруулах ундаа, тамхины бүлгийн 204 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг сараар, бусад бүлгийн 589 төрлийн үнийг улирлаар судлан программын дагуу шивэлтийг хийн хугацаанд нь дамжуулсан.

**Малын ашиг шим нэмүү өртгийн түүвэр судалгаа**

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээний тооцооны туршилтын судалгаа 2 дах жилдээ явагдах болсонтой холбогдуулж ҮСХ-ноос зохион байгуулсан танхимын сургалтанд хэлтсээс 2 мэргэжилтэн хамрагдаж мэдээлэл цуглуулалтын үнэмлэхээ авсан.



Энэхүү судалгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Ах Ахуйн байгууллагын дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран “Малын ашиг шим, нэмүү өртгийг тооцох судалгаа”-г 2024 оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн 10 дугаар сарын 30-ны хугацаанд Эрдэнцагаан, Баяндэлгэр, Уулбаян, Сүхбаатар сумдын нийт 188 өрх, аж ахуй нэгж байгууллага 8, худалдаа эрхлэгч, дамжин борлуулагч 6, мал нядалгааны 6 цэгээс малын жингийн судалгааны мэдээллийг бүрэн цуглуулж ажиллалаа.



Түүвэрт хамрагдсан сумдад “Судалгааг орон нутагтаа хамтран зохион байгуулах” тухай хэлтсийн даргын 36 тоот, ААН-ын дарга, захирал болон хувиараа эрхлэгч нарт “Судалгааны ажилд хамтран оролцох тухай” 38 тоот албан бичиг гарч, заавар зөвлөмжийн хамтаар хүргэгдсэн нь мэдээлэл цуглуулалтын ажилд үр дүнтэй нөлөөлсөн.

## БҮЛЭГ III. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРТАЛЧИЛГАА

### Шалгуур үзүүлэлт-9 Мэдээлэл тархаалт, вэб баяжилт, сурталчилгаа

Статистикийн үйл ажиллагаа болон томоохон тооллого судалгааны ажлын зохион байгуулалт, үр дүнгийн талаар орон нутгийн 1 телевиз, “Сүхбаатарын өнгө” сонин, зам дагуух мэдээллийн самбарт байршуулах, мэдээлэл, танилцуулга гарын авлага хэлбэрээр төрийн байгууллага, иргэдэд хүргэн ажиллаж байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 1-10 дугаар сарын мэдээллээр дараа сарын 15-ны дотор хэвлэлийн бага хурлыг орон нутгийн BBS телевизтэй хамтран нийтдээ 11 удаа зохион байгуулаад байна.

Захиалгын дагуу 2023 оны жилийн эцсийн танилцуулгыг 100 хувь, 2024 оны улирлын танилцуулгыг 43 хувь, сарын танилцуулгыг 84 хувь тус тус захиалгын дагуу хэвлэн тархаасан.

Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд “Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал”-аар бэлтгэсэн персентациар мэдээлэл хийж, сэтгүүлчдийн асуултад хариулж, хэвлэлийн бага хурал болон аймгийн удирдлагууд, агентлаг, албад, ААН-ийн дарга нарын 7 хоног бүрийн Даваа гарагийн цуглаан дээр мэдээлэл хийж хэвшсэн.

Хэлтсийн ажилтнууд “Хүн ам, өрх”, “Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт”, “Хөдөө аж ахуйн салбар”, “Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар”, “Худалдаа, үйлчилгээний салбар”-ын танилцуулга, Статистикийн өврийн дэвтэрийг сүүлийн 5 жилийн байдлаар бэлтгэж боловсруулан тархаасан.



















Зохион байгуулагдаж буй тооллого, судалгаа, хэлтсийн үйл ажиллагааны талаар орон нутгийн хэвлэл болон төв зам дагуу байрлах мэдээллийн самбар хэлтэс болон аймгийн албан ёсны вэб сайт, фэйсбүүк хуудсаар дамжуулан, хүртээмжтэй байдлыг хангах үүднээс цахим хуудаст байршуулан хэрэглэгчдэд мэдээллээ хүргэдэг.

## ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭСЭН БАЙДАЛ

### Хүснэгт 4. Радио, телевиз, сонин хэвлэлээр статистикийн мэдээллээ танилцуулж, сурталчилсан ажил

| № | Тархаасан мэдээллийн агуулга | Хариуцсан ажилтан | Давтамж | Тоо | Хэвлэл мэдээллийн агентлагийн нэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Аймгийн эдийн засаг, нийгмийн байдал” сар бүрийн танилцуулга | Т.Эрдэнэбат<br>Ц.Азжаргал<br>Э.Анхцэцэг<br>С.Мөнхбаяр<br>Б.Сумьяа<br>О.Ундрах | сар бүр | 10 | BBS телевизээр сар бүр мэдээлдэг. |
| 2 | Мал төллөлт, том малын зүй бус хорогдол, хадлан бэлтгэл | Т.Эрдэнэбат | 3, 5-р сард | 2 | BBS телевиз |
| 3 | 2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын дүн | Т.Эрдэнэбат | 1-р сард | 1 | BBS телевиз |
| 4 | Нээлттэй хаалганы өдөрлөг | Т.Эрдэнэбат | 9-р сард | 1 | Sukhbaatarinfo.mn |
| 5 | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн программ хангамж, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого, нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээний шинэчилсэн маягт, программын сургалт | Т.Эрдэнэбат<br>Ц.Азжаргал<br>Э.Анхцэцэг<br>С.Мөнхбаяр<br>Б.Сумьяа<br>О.Ундрах | 11-р сард | 1 | Sukhbaatarinfo.mn |
| | ДҮН | | | 15 | 4 мэдээллийн агентлаг |

### Хүснэгт 5. Статистикийн албыг олон нийтэд сурталчилж зохион байгуулсан нээлттэй өдөрлөг, уулзалт

| | Сэдэв | Зохион байгуулсан ажилтан | Хугацаа | Оролцсон | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Хүний тоо | Байгууллага, ажилтан |
| 1 | “Хууль, эрх зүйн орчин”, “Анхан шатны мэдээ тайлангийн гаргалт, уялдаа, чанар” | Т.Эрдэнэбат, Э.Анхцэцэг С.Мөнхбаяр | 2024.01.29 | 21 | сумын Засаг дарга, Орлогч дарга, Тамгын дарга, багийн Засаг дарга нар, статистик мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн, ХАА-ын мэр-гэжилтэн, Хүн ам зүйч болон холбогдох албан хаагчид |
| 2 | Статистик мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах | Т.Эрдэнэбат | 2024.03.15 | 95 | Аймгийн удирдлагууд, Сумдын засаг дарга, агентлаг албадын дарга |
| 3 | “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа” | Э.Анхцэцэг | 2024.04.01 | 48 | Аймгийн удирдлагууд, агентлаг албадын дарга |
| 4 | “ Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа” | Э.Анхцэцэг | 2024.04.02 | 13 | Сумдын төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга |
| 5 | “МЭ-1 мэдээг гаргах аргачлал, анхаарах асуудлууд” | Т.Эрдэнэбат | 2024.04.17 | 110 | Мал эмнэлэгийн үйл ажиллагаа эрхлэдэг аж ахжй нэгжийн дарга нар болон малын эмч |
| 6 | Малын хагас жилийн түүвэр судалгааны сургалт | Т.Эрдэнэбат, О.Ундрах | 2024.05.21 | 131 | сумын Засаг дарга, Орлогч дарга, Тамгын дарга, багийн Засаг дарга нар, статистик мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн, ХАА-ын мэр-гэжилтэн, Хүн ам зүйч болон холбогдох албан хаагчид |
| 7 | Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа уулзалт, зөвөлгөөн | Т.Эрдэнэбат, Э.Анхцэцэг | 2024.05.28-29 | 50 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 17 уул уурхай компанийн дарга, менежер, нягтлан бодогч нарт |
| 8 | Хаягийн тодруулгыг хийхэд анхаарах асуудал | Т.Эрдэнэбат | 2024.06.13 | 80 | сумын Засаг дарга, Орлогч дарга, Тамгын дарга, багийн Засаг дарга нар, статистик мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн, Хүн ам зүйч болон холбогдох албан хаагчид |
| 9 | Нээлттэй хаалганы өдөрлөг | Т.Эрдэнэбат Ц.Азжаргал Э.Анхцэцэг С.Мөнхбаяр Б.Сумьяа О.Ундрах | 2024.09.18 | 100 | Аймгийн засаг дарга болон, Төрийн албан хаагчид болон иргэд |
| 10 | МАШНӨТС-нд хамрагдсан сумдад | Б.Сумьяа О.Ундрах | 2024.10.02 | 25 | Багийн дарга засаг дарга нар, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | Хаягын орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх системийн сургалт | С.Мөнхбаяр | 2024.10.15 | 40 | Төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүд, нийгмийн бодлогын мэргэжилтэн, сумын төвийн багийн засаг дарга нар |
| 12 | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн программ хангамж, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого, нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээний шинэчилсэн маягт, программын сургалт | Т.Эрдэнэбат<br>Ц.Азжаргал<br>Э.Анхцэцэг<br>С.Мөнхбаяр<br>Б.Сумьяа<br>О.Ундрах | 2024.11.22-23 | 106 | Багийн Засаг дарга нар, статистик мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн, ХАА-ын мэр-гэжилтэн, Хүн ам зүйч болон холбогдох албан хаагчид |
| | ДҮН | | | 819 | |

## ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ СУРТАЛЧИЛГАА

Сүхбаатар аймгийн хэмжээнд явагдаж буй улсын хэмжээний түүвэр судалгаа, тооллогын талаар орон нутгийн BBS телевиз болон хэлтсийн фэйсбүүк хуудас, төв зам дагуу байрлах мэдээллийн самбар, хурал, цуглаанд мэдээлэл хийх зэргээр дамжуулан иргэдэд сурталчлан ажиллаж байна.

### Хүснэгт 6. Тооллого, судалгааны сурталчилгаа хийсэн байдал

| | Сурталчилгаа хийсэн тооллого, судалгаа | Телевиз | Радио | Сонин | Олон нийтийн сүлжээ | Хурал, цуглаан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өрх хүн ам, хөдөө аж ахуйн 2023 оны жилийн эцсийн тооллогын үр дүн | 1 | - | 1 | 1 | 1 |
| 2 | ҮСХ-ноос зохион байгуулан явуулдаг түүвэр судалгаанууд түүний ач холбогдол /ӨНЭЗС, АХС/ | - | - | - | 5 | 3 |
| 3 | Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны ач холбогдол | - | - | - | 3 | 1 |
| 4 | Жилийн эцсинй ААНБ мэдээний ач холбогдол | - | - | - | 2 | 2 |
| 5 | Хүн ам, өрхийн мэдээллийн сангын ач холбогдол | - | - | - | 4 | 4 |
| 6 | Мэдээллийн сангийн ач холбогдол | - | - | - | 4 | 4 |
| 7 | Жилийн эцсийн хүн, ам, мал тэжээвэр амьтад, хашаа худгын тооллого | - | - | - | 1 | 3 |
| | ДҮН | 1 | - | 1 | 20 | 18 |

Аймгийн хэмжээнд 2024 оны 4 дүгээр улиралын байдлаар улсын хэмжээний 1 тооллого, 4 судалгаа явуулсан бөгөөд орон нутгийн телевизэд 1 удаа, сонин 1 удаа, олон нийтийн фэйсбүүк, вэб сайтаар 20 удаа, онлайн хурал цуглаанд 18 удаа мэдээлэл, сурталчилгааны ажил хийсэн.

## МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, ВЭБ БАЯЖИЛТ

**Бюллетень, танилцуулга**



Аймгийн нийгэм эдийн засгийн талаарх мэдээллүүдийг сар, улирал, жилийн давтамжтайгаар нэгтгэн, танилцуулга хэлбэрээр гарган, орон нутгийн удирдлагууд, холбогдох хэлтэс агентлагууд, ААНБ болон хэрэглэгчдэд тархаан ажилладаг. Хэлтсийн даргаар аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга гаргах, мэдээлэл хийх, хэрэглэгчдэд тархаах, вэб-д байршуулах графикийг батлуулж, мэргэжилтнүүд тухайн батлагдсан хуваарийн дагуу заасан хугацаанд мэдээллийг хүргэн ажиллаж байна.




Вэб сайтын “Эмхтгэл, танилцуулга” нэртэй цэсэнд “Эмхтгэл”, “Салбарын танилцуулга”, “Сар бүрийн нийгэм, эдийн засгийн танилцуулга” нэртэй дэд цэсүүдийг үүсгэн хэлтсээс гаргасан эмхтгэл, ном, судалгаа, танилцуулгыг тухай бүр баяжуулан хийдэг.



2024 жилийн эцсийн байдлаар 2023 оны 12-р сар, 2024 оны сар бүрийн аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга, хэвлэлийн бага хурлын презентацийг сар бүр буюу 11 удаа мэдээллийг оруулсан.




Статистикийн бюллетень, танилцуулгыг сар, улирал, жилийн эцсийн байдлаар албан ёсны статистик болон захиргааны статистик мэдээллүүдийг нэгтгэн боловсруулж, товхимол байдлаар, энэ жилийн хувьд “Статистикийн бюллетень, танилцуулга 2023” жилийн эцсийн танилцуулгыг 100 ширхэг, сар бүр 14 ширхэг буюу давхардсан тоогоор 154 ширхэг, улиралд 129 ширхэгийг захиалгын дагуу тархааж, аймаг, сумдын удирдлага, төр, захиргааны агентлаг, хэлтэс, албад, аж ахуй нэгж байгууллага болон иргэдийг орон нутгийн нийгэм, эдийн засгийн мэдээллээр хангаж, үйлчилж ажилласан. Мөн хэлтсийн вэб сайт болон фэйсбүүк хуудаснаа дараа сарын 15-ны дотор байршуулж, мэдээллийг тархаасан.

Сар бүр нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр инфографик хийж, жилийн хугацаанд давхардсан тоогоор 162 ширхэгийг тархааж, хэрэглэгчдийг аймгийн нийгэм, эдийн засгийн мэдээллээр хангаж ажилласан.

**Динамик үзүүлэлт бүрдүүлэлт**




Хэлтсээс вэб сайтын "Танд хэрэгтэй мэдээлэл" гэсэн виджет буланд "**Динамик судалгаа**" нэртэй хуудас нээж салбар бүрийн динамик үзүүлэлтүүдийг аймаг, сум, багийн түвшинд 2023 оноор баяжуулсан.

**Жилийн эмхэтгэл**




2024 онд аймгийн статистикийн эмхэтгэлийг 2023 оны үзүүлэлтээр баяжуулан 20 бүлгийн 116 дэд бүлэгтэй аймгийн нийгэм, эдийн засгийн статистик мэдээллийг 10 жилийн давтамжтайгаар нэгтгэн бэлтгэж гаргасан бөгөөд цахим хэлбэрээр тархаасан.

**Салбарын танилцуулга**

Хэлтсийн ажилтнууд "Хүн ам, өрх", "Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт", "Хөдөө аж ахуйн салбар", "Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар", "Худалдаа, үйлчилгээний салбар"-ын танилцуулга, Статистикийн өврийн дэвтэрийг сүүлийн 5 жилийн байдлаар бэлтгэн гаргаж хэлтсийн вэб сайтад байршуулсан.

Эдгээр сэдвээс гадна ҮСХ-ноос баталсан арга зүйн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга болон түүний хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг агуулсан танилцуулгыг бэлтгэж тархаав. Тухайлбал:

- ✓ Аймгийн нийгэм, эдийн засгийн 2002-2023 оны мэдээллийг 151 үзүүлэлт, 13 сумын мэдээллийг 97 үзүүлэлтээр гаргаж, танилцуулга, илтгэлийг бэлтгэн, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, ажлын алба, аймгийн 33 төлөөлөгч, Засаг дарга, 2 орлогч, 2 зөвлөх болон Тамгын газрын хэлтсийн дарга, ажилтнуудад бэлтгэн өгсөн.

**Инфографик мэдээлэл**

Салбар хариуцсан мэргэжилтнүүд хүн ам, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, эрүүл мэнд, гэмт хэрэг, тээвэр зэрэг 5 салбарын мэдээллийг 5-аас доошгүй жилээр инфографик бэлтгэн, улирал бүр хэлтсийн вэб сайт болон фэйсбүүк хуудаснаа байршуулан ажиллаж байна.



## Шалгуур үзүүлэлт-10 Дотоод үйл ажиллагаа

**Төлөвлөлт, тайлагналт**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 хэсгийн 3 зорилтыг 26 арга хэмжээг тусган боловсруулан Үндэсний статистикийн хорооны даргаар батлуулан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны дарга, аймгийн Засаг дарга, хэлтсийн дарга гэсэн гурвалсан үр дүнгийн гэрээг 2024 онд байгуулан гэрээний ажил үүргээ амжилттай гүйцэтгэн ажиллаж байна.

2024 оны үйл ажиллагаанд мөрдөгдөх тогтоол, шийдвэрийн биелэлтэд байнга хяналт тавьж, биелэлтийг тогтмол цаг хугацаанд нь гаргаж мэдээлдэг. Үүнд: Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын тогтоол 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, Засгийн газрын албан даалгавар 1, аймгийн ИТХ-ын тогтоол 3, Засаг даргын захирамж 15, ҮСХ-ны даргын албан даалгавар 1-ийг хяналтад авч, хууль эрх зүйн цахим санд байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу shilen.gov.mn мэдээллийн сайтад өөрийн байгууллагатай холбоотой мэдээллийг байршуулан ажилласан.

Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 3, Б тушаал 6 нийт 9 тушаалыг Хэлтсийн дарга гарган ажиллаж байна.




Ирсэн, явуулсан бичгийн бүртгэл хийн, бүртгэл хяналтын карт хөтлөн хяналт тавьж ажиллаж байна.

Мөн төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp.e-mongolia.mn/-ээр албан бичгийг бүртгэн хүлээн авч ажилласан.

Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн дотоод ажил үүргийг хуваарийн дагуу ажилтан бүр хариуцан ажиллаж байна.

## Хүснэгт 7. Хэлтсийн дотоод ажил үүргийн хуваарь

| | Дотоод ажил үүрэг | Хариуцах ажилтан |
|---|---|---|
| 1 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн төлөвлөгөө, тайланг боловсруулан нэгтгэх | Хэлтсийн дарга |
| 2 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн ажилтны цаг ашиглалтын бүртгэл | Хүн ам, барилгын салбар хариуцсан мэргэжилтэн |
| 3 | Мониторинг, хяналт шалгалтын ажил | Хэлтсийн дарга |
| 4 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн сүлжээ, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ | Хэлтсийн дарга |
| 5 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн WEB хуудсаар мэдээлэл тархаах | Хэлтсийн дарга, мэргэжилтэнгүүд |
| 6 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн архив, бичиг хэргийн бүртгэл (ирсэн, явсан албан бичиг, и-майл, тогтоол шийдвэр, тушаал, мэдээний ирц) | Нягтлан бодогч, архив бичиг хэрэг |
| 7 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн нярав | Хүн ам, барилгын салбар хариуцсан мэргэжилтэн |
| 8 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн өмч, хөрөнгө хамгаалал, бүртгэл, засвар, үйлчилгээ | Хүн ам, барилгын салбар хариуцсан мэргэжилтэн |
| 9 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн хүний нөөцийн бүртгэл | Хэлтсийн дарга |
| 10 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн хурлын тэмдэглэл хөтлөх, биелэлтэд хяналт тавих | Нягтлан бодогч, архив бичиг хэрэг |
| 11 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах : | |
| | ҮСХ-нд (УИХ, Засгийн газар, ҮСХ, яамтай хамтарсан шийдвэр) | Ахлах мэргэжилтэн |
| | АЗДТГ-т (УИХ, Засгийн газар, НИТХ, Засаг даргын захирамж, албан даалгавар, Засаг даргын мөрийн хөтөлбөр, э\з, нийгмийн зорилт) | Ахлах мэргэжилтэн |
| 12 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн санал асуулгаар авсан үнэлгээг нэгтгэх | Хэлтсийн дарга |
| 13 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн амралт, баяр, спорт зэрэг арга хэмжээ | Нягтлан бодогч, архив бичиг хэрэг |
| 14 | Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн хэвлэл, ТВ, радиод мэдээлэл гаргах, хэвлэл захиалга | Нягтлан бодогч, архив бичиг хэрэг |

## Хүснэгт 8. Хэлтсийн ажилтнуудын 2024 онд ажил орлон гүйцэтгэх хуваарь

| | Албан тушаалын нэр | Ажилтны нэр | 1-р ээлжид орлон гүйцэтгэх ажилтны нэр | 2-р ээлжид орлон гүйцэтгэх ажилтны нэр |
|---|---|---|---|---|
| 1 | Хэлтсийн дарга | Т.Эрдэнэбат | Э.Анхцэцэг | Ц.Азжаргал |
| 2 | Ахлах мэргэжилтэн | Э.Анхцэцэг | С.Мөнхбаяр | Б.Сумъяа |
| 3 | Мэргэжилтэн | О.Ундрах | Б.Сумъяа | С.Мөнхбаяр |
| 4 | Мэргэжилтэн | С.Мөнхбаяр | О.Ундрах | Э.Анхцэцэг |
| 5 | Мэргэжилтэн | Б.Сумъяа | Э.Анхцэцэг | С.Мөнхбаяр |
| 6 | Нягтлан бодогч | Ц.Азжаргал | С.Мөнхбаяр | О.Ундрах |

**Хүний нөөцийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөлт**

Хэлтсийн ажилтнууд болон 13 сумын төрийн сангийн төлөөлөгч, 67 багийн Засаг дарга нарын бүртгэл судалгааны өөрчлөлт, шинэчлэлийг оруулан ажилласан.



2024 онд хүний нөөцөд орсон өөрчлөлт хөдөлгөөний тухай бүр хүний нөөцийн програмд оруулж, мэдээллээ шинэчлэн ажиллаж байна.

Хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах хүүхэд харах чөлөө дуусч 2024 оны 3 дугаар сарын 7-ноос ажилдаа орж, хэлтсийн орон тоо бүрэн нөхөгдөж, одоо хэлтсийн дарга, мэргэжилтэн 4, нягтлан бодогч, судлаач 3 нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

**Засаг даргын үнэлгээ**

Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэлтээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албадаас ДӨРӨВДҮГЭЭР БАЙРАНД шалгарсан.

**Шинэ санаа, санаачилга**

Хэлтсийн ажилтан албан хаагчдын ажиллах орчинг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах гэх мэт олон арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

- Хэлтсийн ахмад ажилтан О.Цэрэндулам, Ц.Хад нарт сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан хүлээн авч гарын бэлэг гардууллаа. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмадын зөвлөлтэй хамтран хэлтсийн 2 ахмадаа амралт сувилал, гадаад аялалд явахад дэмжлэг үзүүлсэн.
- Олон улсын эх үрсийн баяраар байгууллагын ажилтны хүүхэд бүрдээ дундын сангийн мөнгөөр баярын бэлэг өгч баярлууллаа.
- Мэргэжилтэн О.Ундрах охины сэвлэг үргээх ёслолд хүндэтгэл үзүүлсэн.
- Ажилчдыхаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулах үүднээс серверийн төхөөрөмжийн дуу, чимээг багасгаж тусгаарлалт хийлээ.
- Нийт ажилчдадаа хувцас /бомбер/ хийлгэхэд дэмжлэг үзүүлсэн.
- Мэргэжилтэн О.Ундрахын том хүү А.Лхагвадорж гадаад руу сагсан бөмбөгийн төрлөөр “Дэлхийн аварга” шалгаруулах тэмцээнд явахад хэлтсийн хамт олны зүгээс 500.0 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.
- Нийт албан хаагчдыхаа 28 хүүхдийн шүдийг Аймгийн нэгдсэн эмнэлэгт үзүүлж, хүүхэд тус бүр дээр эмчилгээ хийлгэж ажилчдыхаа гэр бүлийн эрүүл мэндийг дэмжлээ.

Шалгуур үзүүлэлт-11

## Статистикийн сургалтын үйл ажиллагаа

Статистикийн салбарын албан хаагчдад зориулсан сургалт

Үндэсний статистикийн хорооноос баталсан хөтөлбөрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах, Төрийн албан хэргийг 2025 оноос эхлэн хос бичгээр хөтлөх тухай шийдвэрийн хүрээнд хорооны зүгээс Монгол бичгийн анхан, дунд түвшний цахим сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдаж байна.

Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан мэдээ, тайлангийн гаргалт, чанар, уялдаа холбоо, албан хэрэг хөтлөлт зэрэг сургалтууд, мөн монгол бичгийн анхан, дунд шатны сургалт, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 цахим сургалтуудад тухай бүр хэлтсийн албан хаагчид хамрагдаж байна.

Хэлтсийн албан хаагчид Сүхбаатар аймгийн төрийн архивын тасгаас 2 дугаар сарын 26-ны өдөр архив, бичиг хэргийн сургалтыг авч ажиллалаа. Уг сургалтаар архив, бичиг хэргийн шинэчлэгдсэн журамтай танилцаж, баримтыг үдэж цэгцлэх арга зүйд суралцсан.



ҮСХ-ны дарга Б.Батдаваа, үнийн албаны дарга Г.Мөнх-оргил нар 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хэлтсийн дарга, албан хаагч нарт Монгол улсын эдийн засаг, дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдлыг танилцуулж, мэдээлэл сургалтыг хийсэн. Цаашид анхаарах асуудал, мэдээ тайлангийн чанарыг сайжруулах талаар заавар зөвлөмж өглөө.

ҮСХ-оос зохион байгуулсан 2024 оны 5 дугаар сарын 23-24-нд Үндэсний өгөгдлийн зөвлөлдөх уулзалт, “мэдээ тайлангийн бодит байдал, чанарыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, анхаарах асуудлууд” сургалтад хэлтсийн дарга, ХАА хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч нар хамрагдсан.




2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээний хүрээнд “Төрийн албан хаагчдад цахим ур чадвар, мэдлэг олгох” сургалтыг аймгийн Засаг даргын тамгын газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс хамтран зохион байгуулан явуулсан. Уг сургалтад цахим шилжилтийн хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй зорилт, бодлого, орон нутагт хэрэгжүүлж байгаа арга хэмжээ түүний дотор “Цахим Сүхбаатар” дэд хөтөлбөр, төрийн байгууллагын цахим ил тод байдал, кибер аюулгүй байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, жендерийн тэгш байдал, төрийн

байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн хэрэглээ хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжийн чиглэлээр өгсөн сургалтад хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг, нягтлан бодогч Ц.Азжаргал нар хамрагдлаа.

2024 оны 7 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Завхан аймгийн Тосонцэнгэл суманд зохион байгуулагдсан “Статистикийн салбарын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт нэгдсэн сургалтад хэлтсийн албан хаагчид оролцсон.

2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-тай хамтран бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх "Цахимд зөв байя" сургалтад хэлтсийн 5 албан хаагч хамрагдсан.

Хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах, Б.Сумъяа нар Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээний тооцооны туршилтын судалгааны сургалтанд хамрагдсан.

Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат Бүгд Найрамдах хятад ард Улсын Үндэсний статистикийн товчооны хоёр талт ажиллагааны хүрээнд Бээжин хотод болсон “Хөдөө аж ахуйн статистик, мал тооллогын чиглэлийн сургалтанд 2024 оны 10 дугаар  сарын 14-18-ны өдрүүдэд оролцлоо.

Хүний нөөцийн асуудал эрхэлсэн албан хаагчдыг чадавхжуулах сургалтанд хэлтсийн дарга Т.Эрдэнэбат хамрагдсан.

Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, хэрэгжилтийн талаар эрхзүйн мэдлэг олгох зөвөлгөөнд хэлтсийн дарга Т.Эрдэнэбат, нягтлан бодогч Ц.Азжаргал нар хамрагдсан.

Орон нутгаас Аймгийн засаг даргын тамгын газар, Нийгмийн даатгалын газар, Татварын алба, Биеийн тамир спортын газар, ЗДТГ-ын архивын хэлтэс, цахим хөгжлийн яамнаас зохион байгуулагдсан 14 удаагийн сургалтуудад хэлтсийн дарга, албан хаагчид хамрагдсан.

**Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт**

Баруун-Урт суманд хэлтсийн дарга Т.Эрдэнэбат, ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг, мэргэжилтэн С.Мөнхбаяр нар 01-р сарын 29-нд анхан шатны мэдээ тайлангийн гаргалттай танилцаж, заавар зөвлөгөөг өгч ажилласан. Мөн сумын ЗДТГ-ын удирдлага, мэргэжилтнүүдэд, багийн Засаг дарга нар болон зохион байгуулагч нарт “Хууль, эрх зүйн орчин”, “Анхан шатны мэдээ тайлангийн гаргалт, уялдаа, чанар” сэдвүүдээр сургалтыг хийсэн.

Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нь аймгийн “Удирдах ажилтны зөвөлгөөн”-д ”Статистик мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах” сэдвийн хүрээнд 90 гаруй албан хаагчдад мэдээлэл сургалтыг хийсэн.

Ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг төрийн албан хаагчдад “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны талаар сургалт мэдээллийг агентлаг албадын дарга нарт танхимаар, сумдын төрийн сангийн мэргэжилтэнүүдэд цахимаар хийсэн.

“Малын хагас жилийн түүвэр судалгаа” бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр сумдын тооллогын комисс, ажлын хэсгийн гишүүдэд мал тооллогын маягт нөхөх заавар, цаашид анхаарах асуудлаар онлайн сургалтыг хийсэн. Хагас жилийн мал тооллоготой холбоотой 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр тооллогын бэлэн байдлыг хангах, сумын засаг даргын захирамж, тооллогын машрут гаргах талаар аймгийн хэмжээнд 59 группын 131 албан хаагч нарт мэдээлэл цуглуулах талаар заавар чиглэл өгсөн.

2024 онд ХАӨМС-гийн үзүүлэлтийг төрийн байгууллагуудын мэдээллийн санд үндэслэн баяжуулах, программ хангамжийг шинэчлэх зорилгоор хаягийн тодруулга хийхэд анхаарах асуудлаар 13 сумын төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт цахим сургалтыг хийлээ.

Мэргэжилтэн О.Ундрах “Малын ашиг шим нэмүү өртөгийн түүвэр судалгаа”-ны талаар судалгаанд хамрагдах Уулбаян, Сүхбаатар, Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумын багийн Засаг дарга нар болон төсөв, төрийн сангийн мэргэжилтэнүүдэд сургалт мэдээлэлийг 4 сумын 25 албан хаагчдад өгсөн.

Мэргэжилтэн С.Мөнхбаяр ХАӨМС*д хаягийн орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх системийн ажлын хүрээнд шинэ болон хуучин хаягаар харагдах байдлаар засвар өөрчлөлтүүдийг хэрхэн хийх талаар 13 сумын 40 албан хаагчдад цахимаар мэдээлэл сургалтыг хийсэн.

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн программ хангамж, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого, нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээний шинэчилсэн маягт, программын сургалтыг Үндэсний статистикийн хорооны Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн ахлах статистикч Ж.Цогзолмаагаар ахлуулсан ажлын хэсэг ирж, статистикийн хэлтсийн хамт олонтой хамтран 2024 оны 11 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд аймгийн нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгуулж, явуулсан бөгөөд сургалтад 13 сумын төрийн сангийн мэргэжилтэн, хүн ам зүйч, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, 67 багийн засаг дарга нар,хэлтсийн мэргэжилтэнгүүд зэрэг нийт 109 албан хаагчид оролцлоо.





### Статистикийн мэдээлэгч нарт зориулсан сургалт

Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нь мал эмнэлгийн ажилчдын зөвлөгөөнд “МЭ-1 мэдээг гаргах аргачлал, анхаарах асуудлууд” сэдвээр мэдээлэл сургалтыг 110 гаруй албан хаагчдад хийсэн.



2024.05.28-2024.05.29-ний хооронд болсон “Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа-2024” уулзалт арга хэмжээнд орон нутгийн удирдлага, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй 17 нэгжийн төлөөлөл, Асгат, Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан зэрэг сумдын удирдлага болон төрийн байгууллага, төрийн бус байгууллагын 50 гаруй төлөөлөл оролцсон. Уг арга хэмжээнд Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат Статистикийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, аж үйлдвэрийн салбарын мэдээ тайлан гаргах аргачлал, цаашид анхаарах асуудлаар сургалт хийлээ.



Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтэс нь Монгол улсад Статистикийн алба үүсгэн байгуулагдсаны 100-н жилийн ойг тохиолдуулан “нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын хурлын зааланд зохион байгуулж явуулсан. Уг нээлттэй хаалганы өдрөөр “Статистикийн салбарын шинэчлэл, хууль эрх зүй, онцлог үйл ажиллагаа” сэдвээр ҮСХ-ны Эдийн засаг статистикийн хэлтсийн дарга М.Оюунжаргал, “Орон нутгийн түвшинд статистикийн үйл ажиллагаа зохион байгуулах, цаашид хэрэгжүүлэх ажил”-аар хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нар илтгэлийг хийж, иргэдэд сургалт, мэдээлэл өгсөн.

| Д/д | Сэдэв | Зохион байгуулсан ажилтан | Зохион байгуул-сан хэлбэр | Хийсэн хугацаа | Оролцсон | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Байгууллаг-ын тоо | Хүн тоо |
| 1 | “Хууль, эрх зүйн орчин”, “Анхан шатны мэдээ тайлангийн гаргалт, уялдаа, чанар” | Т.Эрдэнэбат, Э.Анхцэцэг С.Мөнхбаяр | Танхим | 2024.01.29 | 01 | 21 |
| 2 | Статистик мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах | Т.Эрдэнэбат | Танхим | 2024.03.15 | 01 | 95 |
| 3 | “ Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа” | Э.Анхцэцэг | Танхим | 2024.04.01 | 01 | 48 |
| 4 | “ Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа” | Э.Анхцэцэг | Цахим | 2024.04.02 | 01 | 13 |
| 5 | “МЭ-1 мэдээг гаргах аргачлал, анхаарах асуудлууд” | Т.Эрдэнэбат | Танхим | 2024.04.17 | 01 | 110 |
| 6 | Малын хагас жилийн түүвэр судалгааны сургалт | Т.Эрдэнэбат, О.Ундрах | Цахим | 2024.05.21 | 59 | 131 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа уулзалт, зөвөлгөөн | Т.Эрдэнэбат | Танхим | 2024.05.28-29 | 17 | 50 |
| 8 | Хаягийн тодруулгыг хийхэд анхаарах асуудал | Т.Эрдэнэбат | Цахим | 2024.06.13 | 01 | 80 |
| 9 | Нээлттэй хаалганы өдөрлөг | Т.Эрдэнэбат<br>Ц.Азжаргал<br>Э.Анхцэцэг<br>С.Мөнхбаяр<br>Б.Сумьяа<br>О.Ундрах | Танхим | 2024.09.18 | 36 | 101 |
| 10 | МАШНӨТС-нд хамрагдсан сумдад | Б.Сумьяа<br>О.Ундрах | Цахим | 2024.10.02 | 4 | 25 |
| 11 | ХАӨМС-н сургалтанд хамрагдсан сумд | С.Мөнхбаяр | Цахим | 2024.10.15 | 13 | 40 |
| 12 | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн программ хангамж, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого, нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээний шинэчилсэн маягт, программын сургалт | Т.Эрдэнэбат<br>Ц.Азжаргал<br>Э.Анхцэцэг<br>С.Мөнхбаяр<br>Б.Сумьяа<br>О.Ундрах | Танхим | 2024.11.22-23 | 13 | 106 |

## Шалгуур үзүүлэлт-12 Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа

### Албан хэрэг хөтлөлтийн журам, стандарт

Хэлтсийн бичиг хэргийг стандарт маягтын дагуу хөтөлж ирсэн бөгөөд хэлтсийн мэйлийн бүртгэлийг тусад нь дэвтэр маягтаар хөтөлж хариутай бичгийг бүртгэж байна. Хэлтэст хариутай бичгийн самбарыг ажилтан бүрээр нээж байршуулан ажилтнуудын хариутай бичигт хяналт тавьж ажиллалаа.

Жилийн эцсийн байдлаар 111 бичиг хүлээж авснаас 89 нь хариутай бичиг байсныг тайлант хугацаанд нь барагдууллаа. Байгууллагаас 43 бичиг гарсан.

Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 3, Б тушаал 6 нийт 9 тушаалыг хэлтсийн дарга гарган ажиллаж байна.

Хүснэгт 9. 2024 оны 4-р улирлын байдлаар албан бичгийн шийдвэрлэлт

| Албан бичгийг хүлээн авсан ажилтны нэр | Статистикийн хэлтэст ирсэн | | | Хугацаанд нь хариуг өгсөн | | Статистикийн хэлтсээс явуулсан албан бичиг | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тогтоол, шийдвэр | Албан бичиг | Үүнээс хариутай | Албан бичгээр | Электрон шуудан | хариутай | хариугүй |
| **Нийт дүн** | **8** | **103** | **89** | **8** | **81** | **8** | **35** |
| Хэлтсийн дарга | 4 | 38 | 35 | 4 | 31 | 4 | 30 |
| Мэргэжилтэн | - | 36 | 27 | 1 | 26 | 1 | - |
| Нягтлан бодогч | 4 | 29 | 27 | 3 | 24 | 3 | 5 |

### Архивын ажлын зохион байгуулалт

Архивын хөтлөх хэргийн жагсаалт болон түр хадгалах, байнга хадгалах, 70 жил хадгалах баримтын жагсаалтыг баталж ҮСХ-нд хүргүүлсэн бөгөөд батлагдсан жагсаалтын дагуу үдэж цэгцлэн архивлан холбогдох нэгжийг үүсгэн ажиллаж байна.

## V БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Шалгуур үзүүлэлт-13 Шилэн данс






Шилэн дансны сайт шинэчлэгдсэнтэй холбогдуулан https://gap.mof.gov.mn/ бүртгэлийг цаг тухай бүр хийж “Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээллүүдийг цаг хугацаанд түргэн шуурхай оруулан мэдээлэн ажиллаж байна.

Шилэн дансанд оруулах ёстой мэдээллүүдийг давхардсан тоогоор 2023 оны 32 мэдээлэл, 2024 оны 152 мэдээлэл нийт 184 оруулан мэдээлсэн. Үүнд:




| | Оруулах ёстой мэдээлэл | 2023 оны мэдээлэл | Хугацаандаа оруулсан мэдээлэл | Хугацаа болоогүй мэдээлэл |
|---|---|---|---|---|
| Бүтэн жилээр оруулах мэдээлэл | 11 | 7 | 5 | 6 |
| Хагас жилээр оруулах мэдээлэл | 4 | | 4 | |
| Сар бүр оруулах мэдээлэл | 4 | 4 | 44 | 4 |
| Тухай бүр оруулах мэдээлэл | 9 | 9 | 99 | 9 |
| 2023 оны мэдээллийг шинээр нөхөж оруулсан | | 12 | | |

Шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллийн мөнгөн дүнг цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээ болох 219.8 сая төгрөг, нэмэлт санхүүжилт дансаар орж ирсэн тооллого, судалгааны зардал 14 гүйлгээ болох 184.2 сая төгрөгийн орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4 гүйлгээ болох 38.3 сая төгрөгийн гүйлгээнүүдийг тус тус хугацаанд нь тайлагнан ажиллалаа. Шинээр нэмэлтээр 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэсэн үзүүлэлтийг 2023 оны байдлаар 1-12 сарыг нөхөн оруулж, 2024 оны байдлаар шатахууны худалдан авалт болох 25.3 сая, сургалтын томилолтын зардал болох 20.8 сая төгрөгийн худалдан авалтыг тус тус мэдээлэн ажилласан. Мөн хөрөнгө зарцуулахтай холбоотой Хэлстийн даргын 2 тушаал, Аймгийн Засаг даргын захирамж, Үндэсний Статистикийн хорооны Тамгын газрын даргын сургалтын зардалтай холбоотой тушаал гарсныг шилэн дансанд хугацаанд нь оруулан мэдээлэн ажилласан.

Шалгуур үзүүлэлт-14

## Санхүүгийн тайлан

Манай хэлтэс нь 2024 онд төрийн захиргааны 5 албан хаагч, төрийн үйлчилгээний 1 албан хаагч, судалгааны мэдээлэл цуглуулагч 3, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Эхний 4 дүгээр улирлын байдлаар хэлтсийн үндсэн дансаар 246.3 сая, нэмэлт санхүүжилт дансаар 189.7 сая төгрөг нийт 436.0 сая төгрөгийн санхүүжилтийг аван холбогдох эдийн засгийн ангилалын дагуу зарцуулан өр авлага үүсгээгүй.

4 дүгээр улирлын байдлаар НДШ-н тайлан 12 удаа, Татварын тайлан 4 удаа, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа тус тус хугацаанд нь дамжуулан ажилласан.

### Санхүүгийн тайлан

2023 оны жилийн эцсийн байдлаар үндсэн дансаар 165.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилт дансаар Үндэсний статистикийн хорооноос 183.6 сая төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 14.8 сая төгрөг, нийт 364.3 сая төгрөгийн санхүүжилт авсныг холбогдох зардлын ангилалын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулан ажилласан.

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг "nso.dynamic.mn" програмаар гарган нэгтгэж холбогдох газруудад хугацаанд нь дамжуулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн байдлын тайлан
- ✓ Үр дүнгийн тайлан
- ✓ Өмчийн өөрчлөлтийн тайлан
- ✓ Мөнгөн гүйлгээний тайлан
- ✓ Шалгах баланс /аккурель болон мөнгөн суурьт/
- ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайлан
- ✓ Тодруулга тайлан / үндсэн хөрөнгө, бараа материал, өглөг, авлага, орон тоо, цалингийн сангийн тайлан/

❖ Мөнгөн гүйлгээний тайлан:

Тус хэлтэс нь 2023 онд улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны 165.9 сая төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт дансаар судалгаануудын зардал болох 198.4 сая төгрөгийн санхүүжилт, Засаг даргын нөөц хөрөнгөөс 14.8 сая төгрөгийн санхүүжилт орж ирснээс гүйцэтгэлээр 373.5 төгрөгийг зарцуулсан.

❖ Үр дүнгийн тайлан:

Улсын төсвөөс урсгал үйл ажилалгааны санхүүжилт 165.9 сая төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт дансаар судалгааны зардал 198.4 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 14.8 сая  төгрөгийн санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 828.1 сая төгрөг олж нийт 365.1 сая төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр 394.8 сая төгрөгийн зарлага, ИТХ-н тогтоолоор автомашины гаржыг Сүхбаатар нийтлэг орон нутгийн өмчит үйлчилгээний газарт шилжүүлэн -32.9 сая төгрөгийн үр дүнтэй ажиллалаа.

- ❖ Өмчийн өөрчлөлтийн тайлан

Хуримтлагдсан үр дүн -32.9 сая төгрөг, засгийн газрын оруулсан капитал 76.5 сая төгрөг болсон.

- ❖ Үндсэн хөрөнгийн талаар

2023 оны эхэнд 142.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бөгөөд 2023 онд хэлтсийн эвдэрч муудан ашиглах боломжгүй болсон техник тоног төхөөрөмжүүдийг /0.8 сая төгрөг/, тавилга эд хогшил / 2.2 сая төгрөг/ нийт 3.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнүүдийг Орон нутгийн өмчийн газарт хүсэлт гарган актласан, ИТХ-н тогтоолоол автомашины гражийг Сүхбаатар нийтлэг орон нутгийн өмчийн газар луу шилжүүлэн /5.1 сая төгрөг/, нийт хөрөнгө 133.7 сая төгрөг болж, элэгдлийн зардал 25.7 сая төгрөгөөр байгууллаа.

- ❖ Өглөг авлагын талаар

2023 оны жилийн эцсийн байдлаар өр, авлага үүсгээгүй ажилласан.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын дүгнэлт

Хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн Аудитын газраас түүвэрт хамруулсан тул балансын шалгалт хийгээд дүгнэлт гараагүй.



Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр санхүүгийн nso.dynamic.mn онлайн програмаар гарган хэлтсийн даргаар хянуулан, баталгаажуулж Санхүү, төрийн сангийн хэлтэс болон ҮСХ-нд хүргүүлэн ажиллахаас гадна хэлтсийн вэб хуудас, ил тодын самбар, шилэн дансны нэгдсэн вэб сайтад байршуулан ажиллаж байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргахдаа тухайн жилийн батлагдсан төсөв, сангийн яамны төсвийн хэлбэлзэлтэй тулган баталгаажуулж Санхүү төрийн сангийн хэлтэс болон ҮСХ-нд нийтдээ 12 удаа дамжуулан ажиллаж байна.



Хэлтсийн ил тодын самбар болон шилэн дансанд жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэргийг ил тод иргэдэд мэдээлэн ажиллаж байна.

Санхүүгийн стандарт програмын хэрэглээ

Төрийн албаны гүйлгээний систем цахим болсонтой холбогдуулан finance.gov.mn сайтад эрхийг батлуулан бүх гүйлгээг хийн хэвшин ажиллаж байна.





“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем” болох payroll.gov.mn, Санхүүгийн стандарт програм “nso.dynamic.mn” програмаар 2023 оны санхүүгийн үйл ажиллагааг дуусган жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган дуусгавар болгосон.




2023 оны санхүүгийн үйл ажиллагааг nso.dynamic.mn онлайн програмж шилжүүлэн үндсэн үйл ажиллагааны ажил гүйлгээ болон нэмэлт санхүүжилтийн гүйлгээнүүдийг журналуудад тусгаж, тайлан тэнцлийг улирал, хагас, жилээр санхүүгийн тайланг гаргаж ҮСХороо болон холбогдох газар хэлтсүүдэд хүргүүлж хэвшин ажиллаж байна. Хагас жилийн тайлан гаргахтай холбогдуулан бэлтгэл ажлуудыг хийн ажиллаж байна.

## БУСАД АРГА ХЭМЖЭЭ

**Орон нутагтай хамтран ажилласан ажил**

Аймгийн Засаг даргын тамгын газраас санаачлан зохион байгуулсан “ХАМТДАА ДАВАН ТУУЛЪЯ” малчдад туслах аянд хэлтсийн хамт олон нэгдэж 1 өдрийн цалингаа хандивлалаа.






Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “НЭГ БАЙГУУЛЛАГА-НЭГ САЙН ҮЙЛС” аянд нэгдлээ. 2023-2024 онд аймгийн хэмжээнд байгалийн гамшигт үзэгдэл удаа дараа тохиолдож, малгүй болсон, олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, 1 өрхийг сонгон авч, нэг удаагийн дэмжлэг үзүүллээ.



Уг өрх нь Баруун-Уртын сумын 8-р багийн малчин иргэн н.Эрдэнэцогтынх ам бүл 8-лаа, 4-н хүүхэд, 2 ачын хамтаар амьдардаг. Уг өрх нь өвлийн зуднаар малгүй болсон. Одоогоор эрхэлсэн ажилгүй, эхнэр нь “далай булаг” дэлгүүрт цагийн ажилтай, хувиараа юм хийж зардаг, цэцэрлэгийн нас хүрээгүй 2 ачаа гэрээр хардаг бөгөөд 1 хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй байсан. Манай хэлтэс нь дээрх өрхийн сонгон авч, 1 сарын хүнсний хэрэглээ, хүүхдийн хувцасыг гардуулан өгсөндөө сэтгэл хангалуун байна.

Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 399, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам”, 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийн хүрээнд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ” сэдэвт сургалт ҮСХорооноос 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 14:00 цагт цахимаар зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мөн өдрийн 16:00 цагт аймгийн ОБГазрын "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах дуут дохиоллын дагуу суруулилтын үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын урд буюу Сүхбаатарын талбайд хэлтсийн албан хаагчид оролцлоо.





"ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ СҮХБААТАРЧУУД" уриан дор зохион байгуулагдаж буй бүх нийтийн гүйлтийн арга хэмжээнд хамт олноороо оролцсон.

Хэлтсийн албан хаагчдын бие бялдрын хөгжлийн тодорхойлох сорилд хамрагдсан.

Хэлтсийн албан хаагчид тус бүр хөнгөлөлттэй нөхцөлөөр Ханан фитнестэй жилийн хугацаанд гэрээ байгуулан дасгал хөдөлгөөн хийж хэвшээд байна.

Тус хэлтсийн хамт олон 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр хуваарьт газрынхаа /дөрвөлж толгой цаана байрлах хог ангилах цэгээс дөрвөлж дэлгүүр хүртэлх/ цасыг цэвэрлэж ажиллалаа.

Тус хэлтсийн хамт олон 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр хуваарьт газрынхаа /дөрвөлж толгой цаана байрлах хог ангилах цэгээс дөрвөлж дэлгүүр хүртэлх/ цасыг цэвэрлэж ажиллалаа.





“ТЭРБУМ МОД” үндэсний хөтөлбөрийн хүрээнд манай хэлтсийн хамт олон 5-р тойргийн замын зүүн тал, амгалан хорооллын баруун талын зам дагуух газартаа мод тарих нүхээ, бууц, бор шороогоо бэлтгэж үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих аянд манай хэлтэс нь амгалан хорооллын баруун талын зам дагуух газартаа 15 нүх ухан бууц, бор шороогоо бэлтгэж, 2024 онд 05 дугаар сарын 18-ны өдөр  60 ширхэг хайлаас тарьсан. Нийт 304 модыг арчилж хамгаалан ургуулж байна.

Мөн тарьсан улиас модны тайралт хийн будаж цэгцлэх, 2 хэсэг модны ойр орчмын талбайн зэрлэгийг зулгааж, хогийн түүж цэвэрлэсэн бөгөөд 5-р тойргийн замын зүүн талын модны хашааг мал орохоос сэргийлж засаж ажилласан






Хэлтсийн хамт олон “МАРГААШИЙН ХОГГҮЙ ХУУДСЫГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭЕ” уриан доор зохион байгуулагдаж байгаа хавар, намрын их цэвэрлэгээний ажилд байгууллагын хариуцсан Дөрвөлж толгой цаана байрлах хог ангилах цэгээс Дөрвөлж дэлгүүр хүртэл, Нийгмийн хонгорын хөшөө буюу 5-р тойргийн замын зүүн талд тарьсан өөрийн хариуцдаг модны ойр орчим, амгалан хорооллын замын баруун талд тарьсан модны ойр орчмын цэвэрлэгээг 4 болон 9-р саруудад хийлээ.

Өмнө нь:




Дараа нь:





Ардын хувьсгалын 103 жил, Сүхбаатар аймаг үүсгэн байгуулагдсаны 82 жилийн ойн баяр наадмаар “ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” арга хэмжээнд хэлтсийн ажилтангууд нэгдэж оролцлоо.




Хэлтсийн хамт олон 7 дугаар сарын дунд үеэс эхлэн шарилж, ургамлын ургалт, тоосжилт ихэсч, үрээ цацан иргэдийн ургамлын харшил үүсгэдэг тул Баруун-урт сумын засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 19-ны албан бичгийн доор зохион байгуулагдаж байгаа шарилж устгалын ажилд байгууллагын хариуцсан Дөрвөлж толгой цаана байрлах хог ангилах цэгээс Дөрвөлж дэлгүүр хүртэл, ойр орчмын хог хаягдал болон шарилжын устгал, цэвэрлэгээг 2024.08.03-ний өдөр хийлээ.



Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усны нөөцийг хамгаалах, экологын тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “ Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэлтсийн хамт олон 60 ширхэг хайлаас тарьсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН Т.ЭРДЭНЭБАТ
Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтсийн дарга